



САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ИХ СУРГУУЛЬ
ХУУЛЬ ЗҮЙН СУРГУУЛЬ

Хан-Өндөр
Галсанжигмэдийн ЛХАГВАДУЛАМ

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТУХАЙ ХУУЛИЙН
ХЭРЭГЖИЛТ, ҮР НӨЛӨӨНИЙ ЗАРИМ АСУУДАЛ:
ЗАРДЛЫН ТООЦОО



Мэргэжлийн индекс
042101

Эрх зүйн бакалаврын
Зэрэг горилсон
Дипломын төсөл

Удирдсан
Т. Наранцогт /Ph.D/

Улаанбаатар. 2026



САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ИХ СУРГУУЛЬ
ХУУЛЬ ЗҮЙН СУРГУУЛЬ

Хан-Өндөр
Галсанжигмэдийн Лхагвадулам

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТУХАЙ ХУУЛИЙН
ХЭРЭГЖИЛТ, ҮР НӨЛӨӨНИЙ ЗАРИМ АСУУДАЛ:
ЗАРДЛЫН ТООЦОО



Мэргэжлийн индекс
042101

Эрх зүйн Бакалаврын Зэрэг
Горилсон Дипломын Төсөл

Удирдагч : Т.Наранцогт \Ph.D\

Шүүмжлэгч : Б.Хэрлэнчимэг \Багш\

Улаанбаатар. 2026

ГАРЧГИЙН ТОВЬЁГ

МЭДЭГДЭЛ	i
ТАЛАРХАЛ.....	ii
ТОВЧ ХУРААНГУЙ.....	iii
ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ	iv
ЗУРГАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ	v
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	vi
ОРШИЛ	1
Сэдвийн үндэслэл	1
Сэдвийн судлагдсан байдал.....	1
Сэдвийн зорилго, зорилт.....	2
I. БҮЛЭГ. ХУУЛЬ ТОГТООХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОНОЛЫН ҮНДЭС.....	4
1.1 Хууль тогтоомжийн тухай ойлголт	4
1.2 Эрх зүйг бүтээх үйл ажиллагаа	5
1.3 Хууль тогтоомжийн үр нөлөөг үнэлэх	10
II. БҮЛЭГ. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ЗАРДЛЫН ТООЦООЛОЛ, ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ	12
2.1 Хууль тогтоомжийн зардлын тооцоолол.....	12
2.2 Хууль тогтоомжийн төслийн зардлын шинжилгээ	12
2.3 Хууль тогтоомжийн зардлын тооцооллын аргачлал.....	15
2.4 Хууль тогтоомжийн үр нөлөөг үнэлэх аргачлал	19
2.5 Хууль тогтоомжийн цэвэр өнөөгийн үнэ цэнийг тооцох	20
2.6 Хуулийн төслийн бүрдүүлбэр хангасан эсэх	21
2.7 Монгол улсын хууль тогтоомж, эрх зүйн зохицуулалтын зардлын тооцоо	26
III. БҮЛЭГ. ХАРЬЦУУЛСАН СУДАЛГААНЫ ХЭСЭГ	29
3.1 Монгол улсын хуулийн төсөл боловсруулах аргачлал.....	29
3.2 Австрали Улсын хуулийн төсөл боловсруулах үе шат.....	32
3.3 Бүгд Найрамдах Солонгос Улсын хуулийн төсөл боловсруулах үе шат	37

6.4 Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын хуулийн төсөл боловсруулах үе шат .	42
6.5 Хууль тогтоомжийн төсөл боловсруулах олон улсын туршлага	44
ДҮГНЭЛТ.....	49
ЗӨВЛӨМЖ.....	51
НОМ ЗҮЙ.....	52

МЭДЭГДЭЛ

Энэхүү дипломын төсөл нь миний өөрийн бүтээл болохыг баталж байна. Энэхүү бүтээл нь СЭЗИС-ийн оюуны өмч болох бөгөөд дипломын төслийг номын сангаар дамжуулан нийтийн хүртээл болгохыг зөвшөөрч байна.

Санхүү, Эдийн Засгийн Их Сургуулийн (СЭЗИС) энэхүү бүтээлийг сургалт, судалгаа, ашгийн бус зорилгоор, зохиогчийн эрхийн зөрчлөөс сэргийлэх үүднээс олон улсын Creative Commons Attribution-NonCommercial-NoDerivatives (CC BY-NC-ND) лицензийн дагуу ашиглах эрхтэй.

Нэр: Г.Лхагвадулам

Гарын үсэг:

Огноо: 2026 оны 6 сарын ...-ны өдөр

ТАЛАРХАЛ

Бакалаврын зэрэг хамгаалах энэхүү судалгааны ажлыг хийж гүйцэтгэхэд үнэтэй хувь нэмэр оруулж чиглүүлж, зөвлөсөн Хууль зүйн сургуулийн багш Т.Наранцогт багш болон заавар зөвлөгөө өгч чиглүүлж байсан бүх багш нартаа гүнээ талархсанаа илэрхийлье.

Суралцаж буй хугацаанд хамтдаа хичээл үзсэн, анги хамт олон, анд нөхдөдөө болон СЭЗИС-ийн ажилчид, хамт олон болон эрдэмт багш нартаа баярлалаа.

ТОВЧ ХУРААНГУЙ

Энэхүү дипломын ажил нь Монгол Улсад “Хууль тогтоомжийн тухай хууль”-ийн хэрэгжилт болон хууль тогтоомжийн төсөл боловсруулах зардлын тооцооллын аргачлалыг судлахад чиглэсэн. Судалгааны зорилго нь хууль тогтоомжийн төслийн чанар, хэрэгжилт, үр нөлөөг үнэлэх, мөн тэдгээрийн бодит хэрэгжилтэд нөлөөлж буй сул тал, хүндрэлүүдийг илрүүлэхэд оршино. Ажилд хууль тогтоох үйл ажиллагааны онол, эрх зүйн зохицуулалт, зардлын тооцооллын аргачлал, олон улсын сайн туршлагын судалгааг ашигласан. Судалгааны үр дүнд Монгол Улсын хууль тогтоомжийн төсөл боловсруулах үе шат бүрт гарч буй зардлын ангилал, тооцооллын аргачлал, үр нөлөөний үнэлгээний онцлогийг тодорхойлж, практик хэрэгжилтэд тулгарч буй асуудлыг илрүүлсэн. Мөн Австрали, БНСУ, ХБНГУ зэрэг орнуудын туршлагатай харьцуулсан судалгаа хийж, үндэсний хууль боловсруулах процессын сайжруулалтын санал зөвлөмж гаргасан. Энэхүү судалгаа нь хууль тогтоомжийг боловсронгуй болгох, төсөл боловсруулах зардлыг үнэлэх, үр нөлөөг үнэлэх эрх зүйн ба практик үндэслэлийг хангах, олон нийтийн оролцоог сайжруулахад хувь нэмэр оруулах ач холбогдолтой.

Түлхүүр үгс: *Хууль тогтоомжийн тухай хууль, хууль тогтоомжийн төсөл, зардлын тооцоолол, үр нөлөөний үнэлгээ, зардал-үр өгөөжийн шинжилгээ, хууль тогтоох үйл ажиллагаа, эрх зүйн зохицуулалт.*

ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 0.1. Судлагдсан байдлын судалгаа.....	1
Хүснэгт 2.1. Шалгуур үзүүлэлтэд тохирох хэрэгсэл.....	19
Хүснэгт 2.2. Судлахаар сонгож авсан өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд.....	21
Хүснэгт 2.3. Судалгаа хийгдсэн байдал, хувь.....	24
Хүснэгт 3.1. Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг судлах аргачлал	29
Хүснэгт 3.2. Австрали улсын хуулийн төсөл боловсруулах үе шат.....	32
Хүснэгт 3.3. Бүгд Найрамдах Солонгос Улсын хууль тогтоох үе шат	38
Хүснэгт 3.4. Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын хууль тогтоох үе шат	42
Хүснэгт 3.5. Тандан судлал ба үнэлгээ.....	44
Хүснэгт 3.6. Үзэл баримтлалын төсөл боловсруулах	44
Хүснэгт 3.7. Үр нөлөөний үнэлгээ ба зардлын тооцоолол.....	45
Хүснэгт 3.8. Хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ хийж байгаа эсэх	46
Хүснэгт 3.9. Олон нийтийн оролцоог хэлэлцүүлэг хийж, санал авдаг эсэх	48

ЗУРГАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Зураг 2.1. Хуулийн этгээдийн зардлыг тооцох үе шат	16
Зураг 2.2. Иргэний зардлыг тооцох үе шат	17
Зураг 2.3. Төрийн байгууллагын зардлыг тооцох үе шат	18
Зураг 2.4. 30 хуулийн төсөлд судалгаа хийсэн байдал	24
Зураг 2.5. Шүүх байгуулах тухай хуулийн гэр бүл, хүүхдийн хэргийн шүүх байгуулах зардлын тооцоолол	27

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

Товчилсон үгс	Үгийн тайлбар
УИХ	Улсын Их Хурал
ХТtХ	Хууль тогтоомжийн тухай хууль
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
RIA	Regulatory Impact Assessment- Эрх зүйн зохицуулалтын үр нөлөөний үнэлгээ
CBA	Cost-Benefit Analysis- Зардал, үр өгөөжийн шинжилгээ
NPV	Net Present Value- Цэвэр өнөөгийн үнэ цэнэ
PV	Present Value- Өнөөгийн үнэ цэнэ
PM&C	Department of the Prime Minister and Cabinet- Австралийн Ерөнхий сайд ба Кабинетийн газар
OPC	
Office of impact Analysis	Нөлөөллийн шинжилгээний алба
Korean Law Information Center	БНСУ-ын эрх зүйн мэдээллийн төв

ОРШИЛ

Сэдвийн үндэслэл

Хууль тогтоомж нь нийгмийн харилцааг эрх зүйн тогтолцооны аргаар зохицуулах, төрийн бодлогыг хэрэгжүүлэх эрх зүйн хэм хэмжээ юм. Нийгэм эдийн засаг хурдацтай өсөж хөгжиж байгаагийн хэрээр төрөөс нийгмийн харилцааг зохицуулах бодлого шийдвэр хууль тогтоомжийг боловсруулан гаргадаг. Ингэхдээ тухайн асуудал, нийгмийн нөхцөл байдал зэргийг нарийвчлан судалж судалгаа шинжилгээнд үндэслэн хууль тогтоомжийг боловсруулдаг. Монгол улсад 2015 онд батлагдсан “Хууль тогтоомжийн тухай хууль”-ийг баримтлан хуулийн төслийг боловсруулдаг бөгөөд хууль тогтоомжийг шинжлэх ухааны үндэслэлтэй боловсруулах, тандан судалгаа хийх, зардал үр өгөөжийг тооцох, үр нөлөөг үнэлэх, олон нийтийн харилцааг хангах зэрэг зохицуулалтыг тусгаж өгсөн. хуулийн төсөл боловсруулахдаа “Хууль тогтоомжийн тухай хууль”-д заасан судалгаа шинжилгээ бүрдүүлбэрийг ханган өргөн мэдүүлдэг. Хууль боловсруулах шатанд зарим нь хэрэгжилт хангалтгүй, практикт үр дүн багатай, хуулийн давхардал хийдэл бий болох эрсдэл үүсэж байгаа юм. Энэ нь хууль тогтоомжийг боловсруулах шатанд судалгаа, шинжилгээ, зардал, үр нөлөөний судалгааг хангалттай бодитой хийгдэж байгаа эсэхийг судлах шаардлагатай байна. Түүнчлэн зарим тохиолдолд хуулийн төсөл боловсруулах нь формаль шаардлага хангах түвшинд боловсруулагдаж, хэрэгжилтийн бодит түвшин, эдийн засаг болоод нийгэмд үзүүлэх нөлөөллийг бүрэн тооцоолоогүйгээс хууль хэрэгжих шатанд хүндрэл, нэмэлт зардал, эрх зүйн тодорхойгүй байдал зэрэг нөхцөл байдал үүсэх үндэслэл болж байна.

Сэдвийн судлагдсан байдал

Хууль тогтоомжийн тухай хуулийн хэрэгжилт болон хуулийн төслийн зардлын тооцоололтой холбоотой судалгааны ажил өмнө нь бичигдэж байгаагүй ч түүнтэй төстэй дараах гурван судалгаа тайлан бичигдсэн байна.

Хүснэгт 0.1. Судлагдсан байдлын судалгаа

Судалгааны ажил, нийтлэлүүд	Зохиогч	Он	Судлагдсан агуулга
Хууль тогтоомжийн тухай хуулийн хэрэгжилт: Монгол Улсын Ерөнхийлөгчийн	С.Оюунтуяа, МУИС-ийн докторант, хуульч	2022	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах үе шат бүр Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагыг хангасан эсэх, судалгаа

сонгуулийн тухай хуулийн жишээн дээр авч үзэх нь			шинжилгээ, үнэлгээ, олон нийтийн оролцоо, зардлын тооцоолол, бүрдүүлбэрийн шаардлагыг бодитой мөрдсөн байна уу гэдгийг Ерөнхийлөгчийн тухай хуулийн жишээн дээр судалсан.
Хууль тогтоомжийн хуультай холбоотойгоор бусад улс орнуудын нийтлэг чиг хандлага, сайн туршлагын талаар харьцуулсан судалгаа	Т.Мөнх-Эрдэнэ /Шүүгч, судлаач, LL.M-University of Vienna/ Ц.Одонжав /Хуульчдын холбооны судалгааны төвийн эрхлэгч/ Ц.Мөнх- Эрдэнэ /Судлаач, LL.M-Kookmin University/ Э.Эрхбилгүүн /Судлаач, LL.M- Nagoya University/	2021	Монгол Улсын Хууль тогтоомжийн тухай хуулийг боловсронгуй болгох зорилгоор Австрали, БНСУ, ХБНГУ, Япон улсын хууль тогтоомж боловсруулах, зардлын тооцоо хийх, хүний эрхийн үнэлгээ хийх, олон нийтийн оролцоо хангах, хуулийн бүтэц ба хууль зүйн техник, төслийн бүрдэл хянах, яаралтай хэлэлцэх зэрэг сайн туршлагыг харьцуулан судалсан
Хууль, тогтоомжийн төсөл судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх зарчмын хэрэгжилт	М.Маралмаа Б.Мягмарсүрэн Р.Оюундэлгэр	2025	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах үе шатны судалгаа, шинжилгээ ямар түвшинд хийгдэж байгааг судалсан.

Эх сурвалж: Нээлттэй нийгэм форум <https://forum.mn/>

Сэдвийн зорилго, зорилт

Монгол улсад хуулийн тогтоомжийг боловсруулах ажиллагааг сайжруулах зорилгоор “Хууль тогтоомжийн тухай хууль” болон “Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогоол”-оор аргачлалууд батлагдсан. Дээрх аргачлал нь хууль боловсруулах ажиллагааг зөвхөн улс төрийн болон салбарын хүсэл зоригт тулгуурлуулах бус, тодорхой судалгаа, шинжилгээ, шалгуур үзүүлэлт, зардлын тооцоо, хэрэгжилтийн үнэлгээнд үндэслүүлэх

эрх зүйн суурийг бүрдүүлсэн боловч бодит хэрэгжилтийн шатанд үүсэж буй сул тал, эрсдэлийг бүрэн илрүүлж чадаж байгаа эсэхийг тодорхойлох зорилготой.

Дээрх зорилгын хүрээнд дараах зорилтуудыг тавьж байна. Үүнд:

1. Хууль тогтоох үйл ажиллагааны онолын үндэс, үзэл баримтлалыг судлах
2. Хууль тогтоомжийн зардлын тооцооллын аргачлал, ач холбогдлыг шинжлэх
3. Хууль тогтоомжийн төслийн зардлын тооцоолол нь хэрэгжилт, үр нөлөөнд хэрхэн нөлөөлж байгаа талаар судлах
4. Тухайн хууль нь бодит байдал дээр зорилгодоо хүрч хэрэгжиж чадаж байгаа эсэх, хүндрэл үүсэж байгаа эсэх талаар судлах

I. БҮЛЭГ. ХУУЛЬ ТОГТООХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОНОЛЫН ҮНДЭС

1.1 Хууль тогтоомжийн тухай ойлголт

Хууль тогтоомж гэдэг нь нийгмийн харилцааг эрх зүйн аргаар зохицуулах зорилготой, эрх зүйн хэм хэмжээ агуулсан, төрийн эрх бүхий байгууллагаас батлан гаргасан норматив актын тогтолцоо юм. Хуулийн төсөл гэдэг нь шинээр хууль батлах эсвэл одоо хэрэгжиж байгаа хуульд нэмэлт өөрчлөлт оруулах санал юм. Монгол Улсын эрх зүйн хүрээнд хууль тогтоомжид Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн Улсын Их Хурлаас баталсан хууль болон Улсын Их Хурлын бусад шийдвэр хамаарна. Хууль тогтоомжийн тухай хуульд “хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр”-ийг хууль тогтоомж гэж ойлгохоор тусгасан байдаг. Эрх зүйн онолын үүднээс авч үзвэл хууль тогтоомж нь төрөөс нийгмийн харилцааг зохицуулах, нийтийн эрх ашиг, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, төрийн бодлогыг эрх зүйн хэлбэрээр хэрэгжүүлэх үндсэн хэрэгсэл юм. Өөрөөр хэлбэл, хууль тогтоомж нь зөвхөн бичгээр батлагдсан эрх зүйн акт төдийгүй нийгмийн амьдралыг зохион байгуулах, төр ба иргэн, байгууллага хоорондын харилцааг тогтвортой, шударга, хууль ёсны үндэслэлтэй болгох эрх зүйн механизм гэж ойлгогдоно. Хууль тогтоомжийн тухай ойлголт нь зөвхөн хуулийн текстээр хязгаарлагдахгүй. Үүнд хууль санаачлах, төсөл боловсруулах, хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах, олон нийтийн оролцоог хангах, батлах, хэрэгжүүлэх, үр нөлөөг үнэлэх, нэмэлт өөрчлөлт оруулах, хүчингүй болгох зэрэг цогц үйл ажиллагаа багтана. Хууль тогтоомжийн тухай хуулийн зорилгод хууль тогтоомжийг санаачлан боловсруулах, төсөлд тавигдах шаардлагыг тодорхойлох, олон нийтийн оролцоог хангах, батлагдсан хууль тогтоомжийг нийтлэх, сурталчлах, хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх харилцааг зохицуулахыг заасан байна. Иймээс хууль тогтоомжийн тогтолцоо нь хууль тогтоох үйл ажиллагааны бүх үе шатыг хамарсан эрх зүйн цогц ойлголт юм. Энэ нь хууль тогтоомжийг зөвхөн батлагдсан акт гэж бус, харин судалгаа, үндэслэл, оролцоо, хяналт, үнэлгээнд тулгуурласан тасралтгүй үйл явц гэж үздэг. Энэ утгаараа хууль тогтоомж нь хуулийн засаглалыг хэрэгжүүлэх нэг чухал бүрэлдэхүүн хэсэг болдог. Хууль тогтоомжийн үндсэн элементүүдэд хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр, хууль санаачлах болон боловсруулах ажиллагаа, хэрэгцээ шаардлагын урьдчилсан судалгаа, төслийн үр нөлөөний үнэлгээ, хэрэгжилтийн хяналт, нэмэлт өөрчлөлт, хүчингүй болгох ажиллагаа зэрэг багтана. Эдгээр нь хоорондоо уялдаа бүхий нэг системийг бүрдүүлдэг. Хууль тогтоомжийн төрөлд Монгол Улсын Үндсэн хууль, суурь хууль, ердийн хууль болон Улсын Их Хурлын бусад шийдвэрүүд багтаж болно. Үндсэн хууль нь эрх зүйн дээд хүчин чадалтай хууль бөгөөд төрийн байгуулал, хүний эрх, эрх

чөлөө, төрийн эрх мэдлийн хуваарилалтын үндсийг тогтоодог. Суурь хууль нь эрх зүйн тодорхой салбарыг бүхэлд нь зохицуулдаг бол ердийн хууль нь тодорхой нийгмийн харилцаа, асуудлыг зохицуулахад чиглэгдэнэ. Мөн хууль тогтоомж нь судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх ёстой. Хууль тогтоомжийн тухай хуульд хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах, тухайн асуудлыг хууль тогтоомжоор зохицуулах шаардлагатай эсэхийг тодорхойлох, зохицуулалтын эерэг болон сөрөг талыг харьцуулах, хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг урьдчилан тооцох шаардлагыг тусгасан байна.

1.2 Эрх зүйг бүтээх үйл ажиллагаа

Эрх зүйг бүтээх үйл ажиллагаа нь нэг шаттай, энгийн үзэгдэл биш харин олон түвшин, олон талтай нийгмийн үйл явц юм. Үүнийг социологийн үүднээс судлахдаа дараах хоёр асуудлыг онцлон авч үздэг. Үүнд:

Албан ёсны эрх зүйг бүтээх үйл ажиллагаа

Амьдралын явцад “сүүдрийн” хэм хэмжээ үүсэх үзэгдэл¹

1. Албан ёсны эрх зүйг бүтээх үйл ажиллагаа

Төр, нийгмийн үйл ажиллагааны үр дүнд хуульчилсан акт болон бусад эрх зүйн хэм хэмжээний тогтолцоо бүрэлдэн тогтож, цаашид хадгалагдан хөгжиж байдаг. Энэ бүхнийг албан ёсны эрх зүйг бүтээх үйл ажиллагаа гэж ойлгож болно. Үүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг нь хууль тогтоох үйл ажиллагаа юм. Иймээс эрх зүйн социологи хууль тогтоох үйл явцад тодорхой байр суурь эзэлдэг. Юуны өмнө эрх зүйн социологи нь албан ёсны эрх зүйг бүтээхэд нөлөөлж буй нийгмийн хүчин зүйлсийг илрүүлэхэд чиглэдэг. Эдгээрт эдийн засаг, байгаль газар зүй, экологи, хүн ам зүй, улс төр, эрх зүй, үзэл суртал, сэтгэл зүйн хүчин зүйлс багтана. Ийм судалгаа хийхдээ эрх зүйг бүтээх үйл ажиллагааны үе шат бүрийг социологийн өнцгөөс авч үзэх шаардлагатай.

Хууль боловсруулах ажиллагаа нь хэлбэрийн хувьд ч, агуулгын хувьд ч нийгэм, улс төрийн шинжтэй байдаг. Өөрөөр хэлбэл, эрх зүйг бий болгох үйл явц нь хийсвэр ойлголт биш, харин тодорхой нийгмийн нөхцөл, түүхэн үнэн, бодит амьдралтай салшгүй холбоотой байдаг. Эрх зүйг бүтээх үйл ажиллагааг нийгмийн талаас нь авч үзвэл хэд хэдэн шатанд ангилан ойлгож болно.

Шинэ акт, баримт бичиг боловсруулах үе

Энэ шатанд дараах асуудлыг анхааран судална. Тухайн баримт бичгийг боловсруулахад нийгэм, улс төр, эдийн засаг, нийгмийн ухамсрын ямар хэрэгцээ шаардлага нөлөөлж байна вэ? Ямар бүлэг, давхаргын ашиг сонирхлыг хамгаалж байна

¹ Р.Уранбилэг, 2002, 124 дэх тал

вэ? Гол үзэл санааг хэрэгжүүлэхэд олон нийтийн ямар бүлгүүд, ямар механизмаар нөлөөлж байна вэ? Мөн түүнийг боловсруулах явцад ямар нийгмийн хүндрэл бэрхшээл тулгарч байна, батлагдсан тохиолдолд хэр зэрэг үр өгөөжтэй байх вэ гэдгийг тогтоох шаардлагатай.

Баримт бичгийн анхны төслийг боловсруулах үе

Энэ үед төслийн эхийг ямар арга механизмаар бэлтгэх, ямар нийгмийн хүчин зүйлийг хэр хэмжээнд тусгах, иргэдийн янз бүрийн бүлгийн хөдөлмөр, амьдралын хэв маяг, зан заншил, ашиг сонирхлыг хэрхэн шингээх вэ гэдгийг авч үздэг.

Төслийг хэлэлцэх үе

Хуулийн төслийг хэлэлцэх үед иргэд хэрхэн оролцож байна вэ, ямар бүлгүүд ямар санал гаргаж байна вэ, тэдгээр саналыг хэлэлцүүлгийн явцад хэрхэн харгалзан үзэж байна вэ гэдгийг судална.

Төслийг хууль тогтоох байгууллагад өргөн мэдүүлэх үе

Энэ шатанд төсөлд ямар өөрчлөлт орсон, төрийн болон олон нийтийн янз бүрийн байгууллагын ашиг сонирхол хэрхэн туссан, хэрэгжих боломжийг хэр бодитойгоор үнэлж байгааг шинжилдэг.

Төслийг хууль тогтоох байгууллагад хэлэлцэх үе

Энэ үе шатанд дээрхтэй төстэй асуудлыг авч үзэхийн зэрэгцээ хуулийн төслийг хэлэлцэж буй явцад олон нийт ямар байр суурьтай байгааг мөн анхаарах шаардлагатай.

Баримт бичиг хүчин төгөлдөр болох үе

Хууль, эрх зүйн акт хүчин төгөлдөр болох үед өмнөх шатуудад тавигдаж байсан асуудлууд тухайн агуулгаас шалтгаалан шинэ нөхцөлөөр өөрчлөгдөж болно.

Хоёр дахь чухал чиглэл нь хуульчилсан актуудын маргаантай асуудлыг судалж, түүнд практик зөвлөмж боловсруулах явдал юм. Уг нь хуульчилсан акт нь хуулийг хэрэгжүүлэх зорилготойгоор гардаг болохоос биш, иргэдийн зан үйлийг зохицуулах шинэ хэм хэмжээг дур мэдэн тогтоох ёсгүй. Гэвч бодит амьдрал дээр зарлиг, заавар, тушаалаар Үндсэн хуульд баталгаажгаагүй шинэ үүргийг иргэдэд ногдуулах тохиолдол цөөнгүй байдаг.

Ийм төрлийн актуудын тоог яг таг тогтоох боломжгүй, хэдэн зуугаар хэмжигдэх нь бий. Заримдаа хуульчид хүртэл тэдгээрийн хүрээ хязгаарыг баримжаалахдаа алдаа гаргадаг. Мөн яам, агентлаг, тусгай байгууллагын дотоод хэрэглээнд зориулагдсан шийдвэр, заавар нь хүрээгээ давж, нийт иргэдийн үйл ажиллагааг зохицуулах шинжтэй болж хувирах тохиолдол гардаг. Ийнхүү тушаал, зааврын нэр барьсан зарим албан тушаалтан хууль тогтоогчийн эрх мэдлийг шууд бус хэлбэрээр хэрэгжүүлж, иргэдийн эрх, эрх

чөлөөг хязгаарлах явдал ч байдаг. Үүнийг иргэдийн өргөдөл, гомдлоос тодорхой харж болно.

Гурав дахь асуудал нь эрх зүйг бүтээх үйл ажиллагаанд нийгэм өөрөө хэрхэн нөлөөлж байгааг судлах явдал юм.

Л. Мейхью АНУ-ын эрх зүйн тогтолцоонд иргэн өөрийн төлөөлөгчтэй шүүхээр шүүлгэх эрхтэй байдгийг тэмдэглэсэн байдаг.² Түүний судалгаагаар иргэдийн төлөөлөгчийн үүргийг ихэвчлэн нийгмийн дунд давхаргынхан гүйцэтгэдэг бөгөөд энэ нь тэднийг эрх зүйг бүтээх үйл ажиллагаанд бодитой нөлөө үзүүлэх боломжтой болгодог байна. Мөн Америкийн социологичид зохион байгуулалттай бүлгүүдийн ашиг сонирхол нь хууль хэрэгжүүлэх байгууллагын шийдвэрт ихээхэн нөлөөлдөг болохыг тогтоожээ. Зарим нөхцөлд тухайн байгууллага өөрт ашигтай хэм хэмжээ тогтоох, бүр хуульд байгаагүй бүтцийг бий болгох явдал ч гардаг. Жишээлбэл, тэтгэврийн дээд хэмжээг нэмэгдүүлэх, эсвэл хуульд заагаагүй шинэ зохион байгуулалт бий болгох зэрэг нь ийм шинжтэй.

Мөн өр, авлагыг барагдуулах рэкет шинжтэй бүлэглэл, гэмт хэрэгтэй тэмцэх сайн дурын бүлгүүдийн үүсэл нь төрийн байгууллагын бодлогын алдаа, сул талыг иргэд өөрсдийн аргаар засах, эсэргүүцэх оролдлоготой холбоотой болохыг харуулдаг.

Ийнхүү “сүүдрийн” хэм хэмжээ нь “чи надад — би чамд” гэсэн зарчим дээр тулгуурласан зан үйлийн бүхэл бүтэн тогтолцоог бий болгодог. Социологичдын үзэж байгаагаар бодит амьдрал дахь эрх зүй заримдаа ийм албан бус хэм хэмжээний суурин дээр оршиж байдаг.

2. Хууль тогтоомжийн социологи

Эрх зүйн социологийн бүтцэд хууль тогтоомжийн социологи онцгой байр эзэлдэг. Хууль тогтоох үйл ажиллагааг социологийн судалгаа, шинжилгээгээр хангах зорилготой онол, практикийн цогц судалгааг хууль тогтоомжийн социологи гэж нэрлэнэ.

Үүнийг ерөнхийд нь гурван төрөлд ангилдаг. Үүнд:

“Хууль гарахаас өмнөх үеийн социологи

Хууль тогтоомжийн өөрийнх нь социологи

Хууль гарснаас хойших үеийн социологи”³

Хууль гарахаас өмнөх үеийн социологийн гол зорилго нь эрх зүйн зохицуулалт шаардлагатай байгаа нийгмийн тодорхой асуудлаар олон нийтийн санал бодлыг судлах, ажиглах, мөн эрх зүйн шинжтэй өөрчлөлтөд хүн амын янз бүрийн бүлгийг урьдчилан бэлтгэхэд оршино.

² Р.Уранбилэг, 2002, 126 дах тал

³ Р.Уранбилэг, 2002, 128 дах тал

Харин хууль гарснаас хойших үеийн социологи нь үйлчилж буй хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээний үр нөлөөний талаар олон нийтийн санал бодлыг судлахад чиглэнэ. Практик дээр хууль тогтоогчид хууль батлагдсаны дараа түүний цаашдын хэрэгжилт, хувь заяанд төдийлөн анхаарал хандуулдаггүй. Тийм учраас тухайн хуулийн хэрэгжилт, үр нөлөөний талаар тогтмол судалгаа хийж байх нь эрх зүйн хэм хэмжээ яагаад үйлчлэхгүй байна, эсвэл яагаад сул үр дүнтэй байна гэдгийг тогтооход чухал юм. Хууль тогтоомжийн үр нөлөөг нэмэгдүүлэхийн тулд тухайн нөхцөл байдлаас шалтгаалан төрөөс хууль тогтоомжийг албан ёсоор тайлбарлах, ажлын заавар гаргах, прокурорын хяналтыг сайжруулах, шаардлагатай бол хууль тогтоогчид хандах зэрэг арга хэмжээг авах ёстой.

Хууль тогтоомжийн социологи нь дараах өргөн хүрээний асуудлыг хамардаг. Үүнд эрх зүйн зохицуулалтын хэрэгцээг урьдчилан тогтоох, эрх зүйн хэм хэмжээний актын төсөл боловсруулахад оролцох, хуулийн төсөлд шинжлэх ухаан, практикийн шинжилгээ хийх, шаардлагатай нөхцөлд туршилт явуулах, эрх зүйн шинэчлэл өөрчлөлтийн талаар олон нийтийн санал бодлыг судлах, мөн үйлчилж буй хэм хэмжээний үр нөлөөг шинжлэх зэрэг асуудал орно. Эрх зүйн социологи нь хууль тогтоох үйл ажиллагаа болон хуулийг хэрэглэх практиктай хамтран ажиллах ёстой болохоос тэдгээрийн үүргийг орлох ёсгүй. Хууль тогтоомжийн социологийн судалгаагаар дараах зүйлсийг тодорхойлж болно.

1. Хуулийн төслийг боловсруулах, хэлэлцэх явцад сонирхогч этгээд, бүлгүүд ямар нөлөө, дарамт үзүүлж байгааг илрүүлнэ. Энэ нь лоббизмын асуудал юм. Өөрөөр хэлбэл, төрийн байгууллагын захиргааны үйл ажиллагаанд бүлэг, нэгдэл, хувь хүмүүсийн зүгээс үзүүлж буй нөлөөллийн тогтолцоог тогтоох явдал. Ардчилал, зах зээлийн харилцаа хөгжсөн нийгэмд парламентын гишүүн, албан тушаалтны саналыг худалдаж авах явдал түгээмэл болсон нь үүнтэй холбоотой.

2. Өөрсдийн ашиг сонирхлыг хуульд тунхаглалын хэлбэрээр шургуулан оруулахыг зорьдог улс төрийн, үйлдвэрчний, нийгмийн янз бүрийн бүлгүүдийн арга хэлбэрийг судалж илрүүлнэ.

3. Хуулийг зөрчиж буй нийтлэг хэлбэрүүдийг тогтооно. Өнөө үед Үндсэн хууль дараах хэлбэрээр зөрчигдөх явдал түгээмэл байна. Үүнд Үндсэн хуулийг дур мэдэн тайлбарлах, төрийн байгууллагууд Үндсэн хуулиар тогтоосон эрх мэдлийн хүрээг зөрчих, хэрэг маргааныг шийдвэрлэхдээ Үндсэн хуулийн журмыг мөрдөхгүй байх, Үндсэн хуульд шууд тусгагдсан эрх зүйн актыг хэрэглэдэггүй байх зэрэг орно.

4. Эрх зүйн хэм хэмжээний актын хэрэгжилт, багтаамжийг ажиглан судална. Зах зээлийн эдийн засгийн олон талт харилцааг эрх зүйгээр оновчтой зохицуулах асуудал

өнөөдөр нэлээд бэрхшээлтэй байна. Учир нь хоорондоо зөрчилтэй олон эрх зүйн акт батлагдан гарч байгаа нь иргэдийн дунд эрх зүйд үл итгэх хандлагыг бий болгож байна. Энэ нь тухайн орны өвөрмөц нөхцөл, бодит байдлыг нарийн судлалгүйгээр гаднын хууль, загварыг сохроор хуулбарлаж байгаатай холбоотой. Үүний улмаас шинээр батлагдсан зарим хууль бодит амьдрал дээр хэрэгжихгүй байна. Иймээс нийтийн болон хувийн эрх зүйн харилцааг тэнцвэртэй, оновчтой зохицуулах шаардлага улам бүр нэмэгдэж байна.

5. Эрх зүйн тогтолцооны бодит дүр төрхийг олон нийт болон улс төрчдөд үнэн зөвөөр харуулна. Жишээлбэл, манай улсын хууль тогтоомжид төр иргэнийхээ өмнө хууль зүйн болон эд материалын хариуцлага хүлээх, янз бүрийн хориглолтыг цуцлах, ажил хаялт, жагсаал цуглаан хийхийг зөвшөөрөх, сэтгэл санааны гэм хорыг арилгуулах, иргэн олон улсын шүүхэд хандах зэрэг эерэг шинжүүд бий болсон.

Гэсэн ч үүний зэрэгцээ тодорхой сул талууд ч оршсоор байна. Тухайлбал, эрх зүйн зохицуулалтын хүрээнд байх ёсгүй зарим харилцааг хүчээр зохицуулах оролдлого үргэлжилж байна. Жишээ нь гэр бүлийн гишүүдийн хоорондын зарим харилцаа. Мөн эрх зүйн субъектийн эрх чөлөөг хэт дураар өргөтгөх, “эрх чөлөө”-г “дур зоргоороо авирлах”-тай адилтгах, яам, тусгай байгууллагуудын идэвх хэт өсөж, тэдний гаргасан зааврын дараа л хууль бодитой хэрэгждэг болох зэрэг дутагдал ажиглагдаж байна.

Хууль тогтоомжийн социологийн үндсэн арга нь олон нийтийн санал асуулга юм. Энэ аргаар дамжуулан хүн ам хууль, эрх зүйн талаар ямар ойлголт, хандлагатай байгааг тогтоодог. Албан ёсны бүх нийтийн санал асуулга буюу референдум нь олон нийтийн санал бодлыг илүү тод хэлбэрээр илэрхийлдэг ч олон нийтийн санал асуулга түүнээс илүү уян хатан, нарийвчилсан шинжтэй байдаг.

Сэтгэл зүйн хувьд ч ялгаа бий. Судалгаанд оролцогч хүн сонгуулийн кабинд санал өгч байгаа биш, харин судлаачтай шууд харилцаж буй тул хариулт өгөх үедээ сонгуулийн сурталчилгааны үеийнх шиг дарамт, нөлөөллийг бага мэдэрдэг.

Үндсэн хуулийн референдумыг хууль тогтоомжийн асуудлыг судлах арга болгон ашиглах нь оновчгүй. Харин хууль тогтоомжийн талаар олон нийтийн санал бодлыг судлахдаа асуултыг энгийн, ойлгомжтой байдлаар боловсруулах, “тийм”, “үгүй” гэсэн тодорхой сонголт өгөх нь зүйтэй. Мөн түүврийн хэмжээг тогтоохдоо насанд хүрсэн, сонгуулийн эрхтэй хүмүүсийг хамруулах нь үр дүнг бодит байдалд ойртуулна.

Олон нийтийн санал асуулга нь референдумаас нэг давуу талтай. Тэр нь хүн амын тодорхой бүлгүүдийн, тухайлбал залуучууд, хотын оршин суугчид, ажил эрхлэгчдийн эрх зүйн мэдлэг, чиг хандлагыг тусгайлан судлах боломж олгодогт оршино.

Гэхдээ олон нийтийн санал асуулгын үр дүн нь хууль тогтоогчийн шийдвэрт заавал шууд нөлөөлөх албагүй. Зарим хууль тогтоогч олон нийтийн санал бодлын эсрэг байр суурь баримталдаг. Гэсэн ч энэ нь хууль тогтоомжийн социологийн ач холбогдлыг багасгах үндэслэл болохгүй.

Зарим тохиолдолд олон нийтийн санал бодол нь шинжлэх ухааны тайлбар, төсөөлөлтэй нийцэхгүй, бүр эсрэг, худал мэт санагдаж болно. Ийм үед түүнийг албан ёсны бус, үзэл суртлын нөлөөнд автсан гэж үгүйсгэх нь амархан байдаг.

Гэвч социологич энэ зөрчлийн цаана нуугдаж буй ашиг сонирхлын бодит зөрүүг олж илрүүлж чадвал, олон нийтийн санал бодлоос хууль тогтоогчийн мэдэх шаардлагатай мэдээллийг гаргаж өгч байна гэсэн үг юм. Жишээлбэл, манай улсад 2001 онд Өршөөлийн хууль батлагдах гэж байх үед иргэдийн 40 хувь нь олон хүн суллагдсанаар эрүүгийн нөхцөл байдал хүндэрнэ гэж үзэж байжээ. Тухайн үед хууль тогтоогчид энэ байр суурийг албан ёсны бус гэж үзэж байсан ч уг хууль гарсны дараа онц хүнд, хүнд гэмт хэргийн үзүүлэлт буураагүй, харин өссөн байдаг.

“Сүүлийн жилүүдэд хууль тогтоомжийн хэрэгжилт, үр нөлөөний талаар шинжлэх ухааны үндэстэй, дорвитой социологийн судалгаа хангалттай хийгдэхгүй байгаа нь хууль тогтоогчдыг бодит мэдээллийн хомсдолд хүргэж байна. Мөн зарим судалгаа, мэдээллийн төвүүд 100–200 хүнийг хамарсан санал асуулгын үр дүнг томоохон социологийн судалгаа мэтээр танилцуулж, нийгмийг төөрөгдүүлэх явдал гарч байна. Ийм хэмжээний хэсэгчилсэн санал асуулга нь шинжлэх ухааны хувьд бараг ач холбогдолгүй байдаг. Ийм эргэлзээтэй мэдээлэл хууль тогтоогчдын ширээн дээр очиж байгаа нөхцөлд бид зохих дүгнэлтээ хийх ёстой. Энэ талаар Оросын эрдэмтэн В. В. Лапаева хууль тогтоомжийг социологийн үндэслэлээр хангах хүрээнд мэргэжлийн хуульчдын хийж буй задлан шинжилгээ хангалтгүй байгааг онцлон тэмдэглэсэн нь анхаарал татахуйц юм.”⁴

1.3 Хууль тогтоомжийн үр нөлөөг үнэлэх

Эрх зүйн зохицуулалтын үнэлгээ буюу Regulatory Impact Assessment-RIA хууль тогтоомжийн төсөл эрх зүйн зохицуулалт бий болгохоос өмнө хийгдвэл зохих баримт бичиг юм. Дараах үнэлгээ нь эрх зүйн зохицуулалтыг зохицуулах гэж буй зорилгодоо хүрэх боломжтой эсэхийг нөлөөллийн системтэй шинжилгээг үндэслэж тодорхойлохыг зорьдог. Шинээр бий болох эрх зүйн зохицуулалтууд нь бүрэн дүүрэн тодорхойлогдох боломжгүй үр дагавар үүсэж болзошгүй байдаг. Тиймээс RIA нь баримт нотолгоонд

⁴ Р.Уранбилэг, 2002, 128 дах тал

суурилсан боловсруулалтыг шаарддаг. RIA нь аливаа зохицуулалтын үр нөлөөг зардал, үр ашиг, эрсдэлийн үүднээс үнэлдэг бодлогын нэг хэлбэр юм.

RIA-г ашигладаг улс орнуудын засгийн газар зохицуулалтын зардал, нөлөөллийн хүрээнд дараах дөрвөн үндсэн зорилтыг тодорхойлсон байдаг. Үүнд:

- Засгийн газрын үйл ажиллагааны үр ашиг болон зардлын аль алиныг хамруулсан бодит нөлөөллийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх;
- Бодлогын олон зорилтыг нэгтгэн уялдуулах;
- Ил тод байдал болон зөвлөлдөх үйл явцыг сайжруулах;
- Төрийн хариуцлагыг дээшлүүлэх.⁵

Нэгдсэн үндэсний байгууллагын төрийн захиргааны асуудал эрхэлсэн хорооны хууль тогтоомж, эрх зүйн зохицуулалтын үр нөлөөг үнэлэх зөвлөмж, гарын авлагад хууль эрх зүйн төслийн зардал, үр ашгийн шинжилгээг хийх нь чухал болохыг онцолсон байсан.

Хууль эрх зүйн зохицуулалтын үр нөлөөний дараах алхмуудаар хийгдэнэ.

1. Асуудлыг тодорхойлох
2. Суурь хэмжилтийг тодорхойлох
3. Зорилго ба сонголтуудыг тодорхойлох
4. Шийдвэр гаргах шалгуур ба хөндлөнгийн логик үзүүлэлтүүдийг сонгох
5. Талуудтай зөвлөлдөх
6. Мэдээлэл цуглуулах, зардал, үр ашгийн шинжилгээ хийх
7. Төрөл бүрийн хувилбаруудыг харьцуулах
8. Сонголт хийх
9. Хязгаарлалт ба тодорхойгүй байдал
10. Хяналт шинжилгээ, үнэлгээ⁶

⁵ Ц.Норовдондог, Ш.Рэнчин-Очир, “Хууль, тогтоомжийн төслийн зардал, үр нөлөөг шинжлэх арга зүй: Олон улсын туршлага”, Парламент судалгааны эмхэтгэл, (Улаанбаатар: Улсын Их Хурлын Тамгын газрын Парламентын судалгааны хүрээлэн, 2022), 279 дэх тал.

⁶ Ц.Норовдондог, Ш.Рэнчин-Очир, өмнөх эшлэл 3, 279 дэх тал.

II. БҮЛЭГ. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ЗАРДЛЫН ТООЦООЛОЛ, ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ

2.1 Хууль тогтоомжийн зардлын тооцоолол

Зардал гэдэг нь аливаа үйл ажиллагаа бүтээгдэхүүн, барааг бэлтгэх, нийлүүлэх, борлуулахад зарцуулагдаж байгаа мөнгийг хэлнэ. Хууль тогтоомжийн зардлын тооцоолол гэдэг нь тухайн хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой мөнгөн урсгалыг тодорхойлж байгаа бөгөөд зардал нь дан ганц төсвийн мөнгөн дүнг илэрхийлдэггүй. Хуулийн төслийг баталснаар иргэн, хуулийн этгээд, төрд үүсэж болох шууд болон шууд бус зардлыг урьдаас тооцоолж үнэлэлт дүгнэлт өгөх үйл ажиллагаа юм. Мөн зардлын тооцоололд мөнгөн зардлаас гадна шаардлагатай нөөц, шаардлагатай цаг хугацаа, ачаалал зэрэг төрөл бүрийн үүсэж болох зардлыг урьдчилан тооцоолж тоон үзүүлэлтэд тулгуурлан хэрэгцээт зардлын дүнг тооцоолон хэрэгжилтийн өртөг, шаардлагатай нөөцийн хэрэглээг тооцдог.

Хуулийн тогтоомжийн зардлын тооцооллын үндсэн зорилго нь хуулийн төсөл батлагдан хэрэгжих боломжтой эсэх, хэрэгжилтэд үүсэж болзошгүй хүндрэлтэй нөхцөл байдал бий болж болох эсэх, мэдээ мэдээллээр хангах, үр ашиг өгөөжийн харьцааг тогтоох буюу тухайн хуулийн зорилго зорилт, үзэл баримтлал нь нийгэмд бодитой хэрэгжих эсэхийг судлах юм.

Хууль санаачлагч шинэ зохицуулалт санал болгохоос гадна хэрэгжүүлэхэд ямар нөөц шаардлагатайг судалж тайлбарлах хэрэгтэй болдог. Иймээс энэ нь өндөр хариуцлагыг бий болгодог гэсэн үг юм. Цаашлаад төсвийн бодлогын уялдааг хангах шаардлага үүсэж болох ба иргэний болон хуулийн этгээдэд үүсэж болох ачааллыг тооцоолж хууль хэрэгжих үед хүндрэл үүсэхээс сэргийлэх боломж үүснэ. Хуулийн зардлыг буруу алдаатай мэдээлэл дээр үндэслэн тооцоолох нь хэрэгжилт, үр нөлөөнд сөргөөр нөлөөлдөг тул зардлын тооцоолол нь хариуцлагыг бий болгодог онцлогтой.

2.2 Хууль тогтоомжийн төслийн зардлын шинжилгээ

Зардал үр өгөөжийн шинжилгээ буюу Cost-Benefit Analysis (CBA) нь шийдвэр гаргах үйл ажиллагаанд ихэвчлэн хэрэглэгддэг бөгөөд тодорхой шийдвэрийн үр дүнд бий болох үр ашгийг хэрэгжүүлэхэд шаардлагатай гарах зардалтай харьцуулан үнэлэх арга хэрэгслийг хэлдэг. Зардал, үр өгөөжийн шинжилгээг аливаа нэг бодлого, арга хэмжээ, төсөл хөтөлбөр, зохицуулалтын хувилбаруудын аль нь илүү оновчтой, хэрэгжүүлэхэд үр ашиг өгөөжтэй болохыг тодорхойлдог. Үр өгөөж болон зардлыг тооцоолж харьцуулан дүгнэхдээ тухайн шинжилгээний үе шат бүрийг оновчтой, үндэслэлтэй, бүрэн дүүрэн гүйцэт тооцоолоогүй тохиолдолд буруу эсхүл дутуу

дүгнэлтэд хүрэх эрсдэлтэй бөгөөд үр өгөөжийн шинжилгээг дан ганц тоон мэдээлэл дээр бус ямар асуудал шийдвэрлэх, тухайн асуудлын мөн чанар, хамрах хүрээ, үр дагаврыг бүхэлд нь харгалзан үзэх шаардлагатай байдаг. Зардал үр, өгөөжийн шинжилгээг бизнесийн салбарт түгээмэл ашигладаг бөгөөд хэд хэдэн үе шатыг хэрэгжүүлдэг байна.

1. Зардал, үр өгөөжийн шинжилгээний хүрээг тодорхойлох буюу шинжилгээ хийх үндсэн зорилгыг тогтоож, ямар асуудлыг шийдвэрлэх гэж буй, ямар хувилбаруудыг харьцуулах гэж буй, мөн зардал ба үр өгөөжийн харьцааг тооцохдоо ямар хэмжигдэхүүн, шалгуур үзүүлэлт ашиглахыг тодорхой болгоно.
2. Зардал үр өгөөжид хамруулах зүйлийг тодорхойлох буюу шууд болон шууд бус зардал, үр өгөөж, биет болон биет бус нөлөөлөл, боломжийн өртөг, түүнчлэн алдагдсан боломжийн өртөг зэрэг тухайн тооцоололд зайлшгүй тусгах шаардлагатай үзүүлэлтүүдийг нэг бүрчлэн тогтоож, жагсаана. Энэхүү шат нь чухал хэсэг бөгөөд ямар үзүүлэлтийг авч үзэх нь эцсийн үнэлгээний бодитой байдалд ихээхэн чухал нөлөөтэй.
3. Зардал, үр өгөөжийн тус бүрийн үнэлгээг тогтоох буюу практикт тухайн асуудлын шинж чанараас хамааран зарим үр өгөөж нь бусдаасаа илүү ач холбогдолтой байх тохиолдол байдаг. Жишээ нь тодорхой үр өгөөжийг заавал хүртэх шаардлагатай байх, эсхүл зарим зардал нь богино хугацаанд өндөр дүнтэй мэт харагдавч урт хугацааны үр ашигтай харьцуулахад бага ач холбогдолтой байх зэрэг нөхцөл үүсэж болно. Тиймээс өмнөх шатанд тодорхойлсон зардал, үр өгөөж бүрийг ач холбогдол, нөлөөллийн цар хүрээ, хэрэгжилтийн шаардлага зэргийг нь харгалзан эрэмбэлж, үнэлгээ өгдөг.
4. Зардал, үр өгөөж тус бүрийн нийт утгыг тооцож, хооронд нь харьцуулна. Энэ шатанд өмнөх үе шатуудад тодорхойлж, эрэмбэлсэн үзүүлэлтүүдийн нийлбэр нөлөөллийг тооцож, аль хувилбар нь илүү ашигтай, эсхүл ямар нөхцөлд илүү оновчтой болохыг тогтооно. Өөрөөр хэлбэл, зардал ба үр өгөөжийн харьцааг эцэслэн гаргаж, шийдвэр гаргах үндэслэлийг бүрдүүлдэг.

Хууль бүтээх ажиллагааны хүрээнд зардал, үр өгөөжийн шинжилгээ хийх нь тухайн хууль тогтоомж зорилгодоо хүрэх чадвартай эсэх, мөн санал болгож буй зохицуулалт шаардлагатай бөгөөд зохистой эсэхийг тодорхойлоход онцгой ач холбогдолтой. Гэвч бизнесийн салбартай харьцуулахад хууль тогтоомжийн хүрээнд энэхүү шинжилгээг хийх нь харьцангуй төвөгтэй байдаг. Учир нь бизнесийн салбарт зардал, үр өгөөжийг ихэвчлэн нэг хэмжигдэхүүнээр, өөрөөр хэлбэл мөнгөн дүнгээр илэрхийлж болдог тул тооцоолол хийхэд хялбар байдаг. Харин бодлого, хууль тогтоомжийн үр өгөөж, өөрөөр хэлбэл тухайн хуулийг баталснаар бий болох эерэг үр

нөлөө нь ихэнх тохиолдолд биет бус шинжтэй, урт хугацааны дараа илэрдэг онцлогтой байдаг. Тухайлбал, хууль хэрэгжсэнээр нийгмийн тогтвортой байдал сайжрах, иргэдийн эрх хамгаалалт дээшлэх, төрийн үйлчилгээний чанар нэмэгдэх зэрэг үр өгөөж нь мөнгөн дүнгээр шууд хэмжихэд төвөгтэй байдаг.

Үүнээс гадна, хууль тогтоомжийн хэрэгжилтээс үүдэн гарах зардлыг зөвхөн нэг талын оролцогчоор хязгаарлах боломжгүй байдаг. Өөрөөр хэлбэл, хувь хүн, нийгмийн тодорхой бүлэг, аж ахуйн нэгж, төрийн байгууллага, төр засаг зэрэг олон талт оролцогч тус бүрийн түвшинд зардлыг ялган тодорхойлох шаардлага үүсдэг. Энэ нь хууль тогтоомжийн нөлөөлөл олон талд зэрэг хүрдэг, мөн тухайн нөлөөлөл оролцогч бүрд өөр өөрөөр илэрдэгтэй холбоотой. Иймээс хууль боловсруулах шатанд хийгдэх зардал, үр өгөөжийн шинжилгээ нь бизнесийн салбар дахь ижил төрлийн шинжилгээнээс илүү нарийн, дэлгэрэнгүй аргачлал шаарддаг.

Түүнчлэн, хуулийн зорилго, тухайн хуулийг батлах хэрэгцээ шаардлага, нийгэм, эдийн засаг, эрх зүйн орчны онцлог зэрэг олон хүчин зүйлээс хамааран үр өгөөж, зардлын харьцаа заавал эерэг байх албагүй. Өөрөөр хэлбэл, зардал, үр өгөөжийн харьцаа сөрөг гарсан тохиолдолд ч тухайн хуулийг зайлшгүй батлах шаардлага үүсэж болно. Ийм нөхцөлд зардал өндөр байх нь дангаараа тухайн зохицуулалтыг хэрэгжүүлэхээс татгалзах үндэслэл болохгүй бөгөөд нийгмийн зайлшгүй хэрэгцээ, нийтийн ашиг сонирхол, үндэсний аюулгүй байдал, хүний эрхийн хамгаалалт зэрэг бусад чухал хүчин зүйлсийг давхар харгалзан үзэх шаардлагатай болдог.

Монгол Улсын хувьд Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 болон 8.1.13-т заасны дагуу хууль тогтоомжийн төсөл боловсруулахаас өмнө хийгдэх тандан судалгааны явцад сонгон авсан зохицуулалтын хувилбаруудын эерэг болон сөрөг талыг тогтоох зорилгоор зардал, үр өгөөжийн харьцааг ерөнхий байдлаар тодорхойлдог. Энэ шатанд гаргах тооцоо нь ихэвчлэн нарийвчилсан тоон судалгаа бус, харин ерөнхий төсөөллийн түвшинд хийгддэг. Тухайлбал, “зардал их гарна”, “зардал бага гарна”, “зардал гарахгүй” гэх мэт ерөнхий үнэлгээ өгч, тухайн зохицуулалтын хувилбаруудыг харьцуулан авч үздэг. Ийнхүү ерөнхий үнэлгээ хийх нь хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажлыг эхлүүлэхээс өмнө аль хувилбар илүү боломжтой, хэрэгцээтэй болохыг урьдчилан тогтооход чиглэдэг.

Харин хуулийн төсөл боловсруулсны дараа зардлын нарийвчилсан тооцоог дахин хийдэг. Хууль тогтоомжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-

т заасан аргачлалын дагуу тодорхойлно” гэж заасан байдаг. Энэ зохицуулалтаас үзэхэд хуулийн төсөл батлагдсанаар ямар зардал үүсэхийг урьдчилан тооцож, түүнийг үнэлэх нь хууль тогтоомж боловсруулах үйл ажиллагааны зайлшгүй бүрэлдэхүүн хэсэг болох нь харагдаж байна.

Мөн Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал”-ыг баталсан. Энэхүү аргачлал нь хууль тогтоомжийн төслийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор гарах зардлыг тооцох нэгдсэн суурь, чиглэлийг тогтоож өгсөн баримт бичиг юм. Өөрөөр хэлбэл, энэ аргачлалын дагуу гарах зардал болон үр өгөөж тус бүрийг тогтоох, тэдгээрийг эрэмбэлэх, үнэлэх, цаашлаад зардлыг бууруулах боломжийг судлах замаар тухайн хууль тогтоомжийн төслийг баталснаар үүсэх зардал нь “Үр ашигтай зардал” байж чадах эсэхийг тодорхойлох боломж бүрддэг.

Иймээс Зардлын тооцоо хийх аргачлал нь зөвхөн зардлын хэмжээг тооцоход бус, харин тухайн хууль тогтоомжийн төслийг хэрэгжүүлэх нь нийгэм, эдийн засаг, төрийн үйл ажиллагаанд ямар нөлөө үзүүлэх, түүний үр өгөөж нь гарах зардлаа зөвтгөхүйц эсэхийг тогтоох удирдамжийн шинжтэй юм. Энэ утгаараа хууль тогтоомжийн төслийн чанар, хэрэгжих боломж, бодит үр нөлөөг урьдчилан үнэлэхэд зардал, үр өгөөжийн шинжилгээ онцгой ач холбогдолтой гэж үзнэ.⁷ (М.Маралмаа, 2025)


2.3 Хууль тогтоомжийн зардлын тооцооллын аргачлал

Монгол улсад “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал” хэрэгжиж байгаа бөгөөд дараах аргачлалд хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон иргэний, хуулийн этгээдийн, төрийн байгууллагаас гарах зардлыг тооцон тухайн зардлыг бууруулах арга замыг тодорхойлохыг зорилго болгодог.

1. Хуулийн этгээдийн зардлыг тооцох ажлыг дараах үе шаттайгаар зохион байгуулна.

⁷ Нээлттэй нийгэм форум, “Хууль, тогтоомжийн төсөл судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх зарчмын хэрэгжилт”, (Улаанбаатар: Нээлттэй нийгэм форум, 2025), 49 дэх тал.

Зураг 2.И.1. Хуулийн этгээдийн зардлыг тооцох үе шат



1.1 Хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох

Хуулийн төсөл батлагдсанаар хуулийн этгээд ямар үүрэг гүйцэтгэх, өмнө нь гүйцэтгэж байсан үүрэг хэрхэн өөрчлөгдөхийг нэг бүрчлэн тогтооно.

1.2 Зардлыг тооцох

Тодорхойлсон үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай үйл ажиллагаануудын тодорхойлно. Үүнд:

- Тухайн үйл ажиллагааг гүйцэтгэх ажилтны ажлын хөлс
- Зарцуулах хугацаа
- Мэдээлэл бэлтгэхтэй холбогдох хэрэгжүүлэх үйл ажиллагаа

Ажлын хөлсийг тухайн салбарын дундаж цалин хөлсөөр тооцно.

$$\text{Ажлын хөлс} = \text{Үндсэн цалин} \div \text{Ажиллах хугацаа}$$

1.3 Тоон үзүүлэлт тогтоох

Тухайн үүргийн хэдэн хуулийн этгээд жилд хэдэн удаа хэрэгжүүлэхийг тооцно.

$$\text{Тоон үзүүлэлт} = \text{Тохиолдлын тоо} \times \text{Давтамжийн тоо}$$

Тохиолдлын тоо гэдэг нь тухайн үүргийг хэдэн хуулийн этгээдэд хүлээлгэж байгааг илэрхийлнэ. Ингэхдээ статистикийн тоо мэдээг ашиглах ашиглах бөгөөд байхгүй бол баримжаалан тооцно. Давтамжийн тоо гэдэг нь тухайн үүргийг 1 жилд хэдэн удаа хэрэгжүүлэхийг харуулна.

1.4 Нийт зардлын дүнг тооцох

Үүрэг тус бүрийн зардал болон тоон үзүүлэлтийг тогтоосны дараа нийт зардлыг дараах томъёогоор гаргана:

$$\text{Нийт зардал} = \text{Зардал} \times \text{Тоон үзүүлэлт}$$

1.5 Хялбарчлах боломжийг шалгах


Тухайн үүргийг хялбарчлах, зардлыг бууруулах боломж байгаа эсэхийг шалгах явдал.

Асуултын аргаар зардлын багасгах боломж байгаа эсэхийг шалгана. Жишээ нь:

- Хамрагдах хуулийн этгээдийн тоог багасгаж боломжтой эсэх
- Шинэ үүргийг өмнө нь байсан үүрэгтэй нэгтгэх боломжтой эсэх гэх мэт

2. Иргэний зардлыг тооцох

Зураг 2.П.2. *Иргэний зардлыг тооцох үе шат*



Иргэний зардлыг тооцохдоо мөнгөн зардлаас гадна цаг хугацааны ачааллыг тооцохоор тусгасан байна. Иргэнээс шаардагдах төлбөрийн хураамж гадна тухайн иргэний мэдээлэл цуглуулах, маягт бөглөх, холбогдох газарт өгөх зэрэг түүнд зарцуулагдаж байгаа цаг гүйцэтгэлийн хугацааг тооцно. Мөнгөн зардлыг тооцохдоо үүргийг гүйцэтгэхэд гарсан замын зардлыг тооцохгүй. Тоон үзүүлэлт тооцох үе шатанд иргэн үүргийг гүйцэтгэхэд хэдэн удаа хэрэгжүүлэхийг хуанлийн 1 жилээр тооцож гаргах бөгөөд тоон үзүүлэлт тохиолдлын тоо болон давтамжийн тоо ашиглан тооцно.

$$\text{Тоон үзүүлэлт} = \text{Тохиолдлын тоо} \times \text{Давтамжийн тоо}$$

$$\text{Ачаалал} = \text{Цаг хугацаа} \times \text{Тоон үзүүлэлт}$$

3. Төрийн байгууллагын зардал тооцох

Төрийн байгууллагын зардлыг тодорхойлсноор улсын төсөвт үзүүлэх ачааллыг тооцож байгаа юм. Гол үүсэж байгаа ойлголт нь хүний нөөцийн хэрэгжээ бөгөөд шинээр хууль, эрх зүйн зохицуулалт хийхэд төрөөс ямар ажил үйлчилгээ түүнд хэдий хэмжээний ажилтан, ажлын цаг, нөөцийн хэрэглээ хэрэгтэй болохыг тогтоох юм.

Төрийн зардлыг дараах үе шаттайгаар тооцоолно.

Зураг 2.П.3. Төрийн байгууллагын зардлыг тооцоох үе шат



Тохиолдлын тоог тогтоох боломжтой, тогтоох боломжгүй гэж ангилдаг. Тогтоох боломжтой тохиолдлын тоо гэдэг нь статистик мэдээлэл, судалгаагаар тогтоогдож болдог. Тогтоох боломжгүй тохиолдлын тоо гэдэг нь үргэлжилсэн, тасралтгүй шинжтэй хийгддэг ажил, үйлчилгээнд хамаардаг.

- Тохиолдлын тоог тогтоох боломжтой үед

$\text{Хүний нөөцийн хэрэгцээ} = \text{Зарцуулах хугацаа} \times \text{Тохиолдлын тоо}$

- Тохиолдлын тоог тогтоох боломжгүй үед

$\text{Хүний нөөцийн хэрэгцээ} = \text{Тоо(баримжаагаар)}$
--

Гарах зардлыг урьдчилан тооцох үед дараах зардлыг тооцдог.

Хүний нөөцийн зардал нь тухайн үүргийг гүйцэтгэх албан хаагчийн авч болох бүх нэмэгдэл, цалин, төрөөс даадаг бүх зардлын дундаж.

Материаллаг зардал нь үйл ажиллагаа явуулж буй байртай холбоотой гарах зардал.

Бусад зардал гэдэг нь ажил үйлчилгээг гүйцэтгэхтэй холбогдон гарах зардлыг хэлдэг.

Нийт зардлыг тооцохдоо хүний нөөц, материаллаг, бусад зардлын нийлбэрийг хүний нөөцийн хэрэгцээнд үржүүлэн гаргана.

$\text{Нийт зардал} = (\text{хүний нөөцийн зардал} + \text{материаллаг зардал} + \text{бусад зардал}) \times \text{хүний нөөцийн хэрэгцээ}$

Хялбарчлах боломжийг шалгаж үр дүнг танилцуулах үе шатанд нийт зарах зардлыг багасгах, эдийн засгийн дарамт багатай өөр боломж байгаа эсэхийг шалгана.

2.4 Хууль тогтоомжийн үр нөлөөг үнэлэх аргачлал

Хууль тогтоомжийн үр нөлөөг үнэлэх ажиллагааг дараах үе шатын дагуу зохион байгуулна

1. Шалгуур үзүүлэлт сонгох
2. Хуулийн төслөөс үр нөлөөг тооцох хэсгийг тогтоох
3. Шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх

1. Шалгуур үзүүлэлт сонгох

Үндсэн шалгуур нь дараах төрөлтэй байна.

1. Зорилгод хүрэх байдал (Хуулийн төсөлд тусгасан зохицуулалт, арга хэмжээ нь тавьсан зорилгодоо хүрэх боломжтой эсэхийг үнэлнэ.)
2. Практикт хэрэгжих боломжтой байдал (Хуулийн төслийг хэрэгжүүлэх байгууллага, этгээд байгаа эсэх, хэрэгжүүлэх санхүү, хүний нөөц, зохион байгуулалтын боломж байгаа эсэхийг шалгана.)
3. Ойлгомжтой байдал (Хуулийн төслийн зохицуулалт хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдэд ойлгомжтой, логик дараалалтай эсэхийг үнэлнэ.)
4. Хүлээн зөвшөөрөгдөх байдал (Тухайн зохицуулалт иргэн, байгууллага, хуулийн этгээдэд хэрхэн нөлөөлөх, тэдгээр этгээд хүлээн зөвшөөрөх эсэхийг судална.)
5. Зардал (Хуулийн төсөл батлагдсанаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, улсын төсөвт ямар зардал, ачаалал үүсэхийг тооцно.)
6. Харилцан уялдаа (Хуулийн төслийн зүйл, заалт өөр хоорондоо болон хүчин төгөлдөр үйлчилж буй бусад хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэхийг шалгана.)

4. Хуулийн төслөөс үр нөлөөг тооцох хэсгийг тогтоох

Хоёр дахь шатанд хуулийн төслийн аль зохицуулалт, зүйл, заалтыг үнэлэхийг тогтооно. Үр нөлөөг үнэлэх хэсгийг сонгохдоо тухайн хуулийн төслийн гол үр дагавар үүсгэх, эрх, үүрэг бий болгох, зардал гаргах, иргэн, хуулийн этгээдэд ачаалал үүсгэх зохицуулалтыг сонгох нь зүйтэй.

5. Шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох

Хүснэгт 2.1. Шалгуур үзүүлэлтэд тохирох хэрэгсэл

Шалгуур үзүүлэлт	Тохирох шалгах хэрэгсэл
Зорилгод хүрэх байдал	Зорилгод дүн шинжилгээ хийх

Шалгуур үзүүлэлт	Тохирох шалгах хэрэгсэл
Практикт хэрэгжих боломж	Практикт турших
Ойлгомжтой байдал	Ойлгомжтой байдлыг шалгах
Хүлээн зөвшөөрөгдөх байдал	Хүлээн зөвшөөрөгдөх байдлын судалгаа хийх
Зардал	Зардлын тооцоо хийх
Харилцан уялдаа	Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах

Эх сурвалж: Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем legalinfo.mn

6. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх

Сүүлийн шатанд үнэлгээний үр дүнг нэгтгэн дүгнэж, зөвлөмж боловсруулна. Энэ үе шат нь дараах дарааллаар явагдана:

1. Үр дүнг баримтжуулах
2. Үнэлэх
3. Зөвлөмж өгөх

2.5 Хууль тогтоомжийн цэвэр өнөөгийн үнэ цэнийг тооцох

$$NPV = \sum_{n=1}^N \frac{R_t - E_t}{(1 + k_t)^n} = \frac{B_1}{(1 + k_1)^1} + \frac{B_2}{(1 + k_2)^2} \cdots \frac{B_N}{(1 + k)^N} - I_{(0)}$$

NPV Цэвэр өнөөгийн үнэ цэнэ

R Өгөөж буюу орох урсгал (тухайн зохицуулалтаас бий болох ашиг, орлого, хэмнэлт зэрэг)

E Зардал буюу гарах урсгал (тухайн зохицуулалтыг хэрэгжүүлэхэд шаардагдах бүх зардал)

B Benefit буюу цэвэр үр ашиг (үр ашиг-зардал)

k Хорогдуулалтын хувь

N Хугацаа (Тухайн хууль, төсөл, зохицуулалтын үр нөлөө хэдэн жил, хэдэн хугацаанд үргэлжлэхийг илэрхийлнэ)

I(0) Анхны хөрөнгө оруулалт (төслийг хэрэгжүүлэхэд гарах эхний зардал)

NPV (Net present value) буюу цэвэр өнөөгийн үнэ цэнэ нь тухайн хууль, төслийг хэрэгжүүлэхэд гарах ирээдүйн үр ашиг зардлыг өнөөдрийн мөнгөний үнэ цэнд

шилжүүлэн анхны хөрөнгө оруулалтыг хассаны дараа хэдий хэмжээний цэвэр ашиг үлдэхийг харуулдаг юм.

$$PV = \frac{B_1}{(1 + k_1)^1} + \frac{B_2}{(1 + k_2)^2} + \dots \frac{B_N}{(1 + k_n)^N}$$

PV нь зөвхөн ирээдүйн өгөөжийг өнөөдрийн дүнгээр харуулж байгаа юм.

2.6 Хуулийн төслийн бүрдүүлбэр хангасан эсэх

Доорх хүснэгтэд өргөн мэдүүлсэн нийт 30 хуулийн төслийг сонгон авч, тэдгээрийн бүрдүүлбэр, судалгаа-шинжилгээний баримт бичиг, зардлын тооцоолол, үр нөлөөний үнэлгээ, хэрэгцээ шаардлагын тандан судалгаа хийгдсэн эсэхэд дүн шинжилгээ хийсэн. Судалгааны гол зорилго нь Хууль тогтоомжийн тухай хууль болон холбогдох аргачлалд заасан шаардлагууд хуулийн төсөл боловсруулах практикт бодитой хэрэгжиж байгаа эсэхийг тодорхойлох явдал юм.

Хүснэгт 2.2. Судлахаар сонгож авсан өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд

№	Хуулийн нэр	Хууль санаачлагч
1	Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай	УИХ-ын гишүүн
2	Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	УИХ-ын гишүүн
3	Гадаад зээлийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төсөл	Монгол Улсын Засгийн газар
4	Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	УИХ-ын гишүүн
5	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай	УИХ-ын гишүүн
6	Татварын ерөнхий хууль нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Монгол Улсын Засгийн газар

7	Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Монгол Улсын Засгийн газар
8	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл	УИХ-ын гишүүн
9	Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай	УИХ-ын гишүүн
10	Улсын нисэхийн тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн төсөл	Монгол Улсын Засгийн газар
11	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай /шинчилсэн найруулга/	Монгол Улсын Засгийн газар
12	Хувийн нэмэлт тэтгэврийн тухай	Монгол Улсын Засгийн газар
13	Төрийн нууцын тухай хууль (Төрийн болон албаны нууцын тухай хуулийн шинэчилсэн найруулга)-ийн төсөл	Монгол Улсын Засгийн газар
14	Санхүүгийн хоршооны тухай /шинчилсэн найруулга/	УИХ-ын гишүүн
15	Сургуулийн орчны эрүүл мэнд, аюулгүй байдлын тухай	УИХ-ын гишүүн
16	Эдийн засгийн эрх чөлөөний тухай	Монгол Улсын Засгийн газар
17	Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Монгол Улсын Засгийн газар
18	Нийгмийн ажлын тухай	УИХ-ын гишүүн
19	Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай /шинэчилсэн найруулга/	УИХ-ын гишүүн


20	Гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төсөл	Монгол Улсын Засгийн газар
21	Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	УИХ-ын гишүүн
22	Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	УИХ-ын гишүүн
23	Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай	Монгол Улсын Засгийн газар
24	Хянан шалгах түр хороо байгуулах тухай	УИХ-ын гишүүн
25	Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай	Монгол Улсын Засгийн газар
26	Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	УИХ-ын гишүүн
27	Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	УИХ-ын гишүүн
28	Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	УИХ-ын гишүүн
29	Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	УИХ-ын гишүүн
30	Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	УИХ-ын гишүүн

Эх сурвалж: Монгол Улсын Их Хурал <https://d.parliament.mn/>

Дээрх сонгон авсан хуулийн төслүүдийн 10 нь анхдагч хуулийн төсөл, хуулийн шинэчилсэн найруулгын төсөл 5, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах 15-н хуулийн төсөл тус тус сонгон авсан. Нийт өргөн мэдүүлсэн 30 хуулийн төслөөс 20-н хуулийн төсөлд хууль тогтоомжийн хэрэгцээ шаардлагын тандан судалгаа эсхүл хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг хийсэн байна. Үүнээс 6 нь хэрэгцээ шаардлагын

тандан судалгаа 14 нь хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийсэн байна. Мөн хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээг 23-д хийсэн, 21-н хуулийн төсөлд зардлын тооцоолол хийгдсэн байна.⁸

Зураг 2.4. 30 хуулийн төсөлд судалгаа хийсэн байдал



Судалгааны явцад нийт 30 хуулийн төслөөс 20 төсөлд хууль тогтоомжийн хэрэгцээ шаардлагын тандан судалгаа эсхүл хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийгдсэн байна. Энэ нь нийт судлагдсан төслийн 66.7 хувийг эзэлж байна. Үүнээс 6 төсөлд хэрэгцээ шаардлагын тандан судалгаа, 14 төсөлд хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийгдсэн байна. Харин 10 хуулийн төсөлд энэ төрлийн судалгаа, үнэлгээ хангалттай тусгагдаагүй нь хуулийн төсөл боловсруулах шатанд судалгаа, шинжилгээний шаардлага бүрэн хэрэгжихгүй байгааг харуулж байна.

Хүснэгт 2.3. Судалгаа хийгдсэн байдал, хувь

№	Хуулийн төсөл	Судалгааны төрлүүд	Судалгаа гүйцэтгэсэн байдал	Тоо	Хувь
1	Анхдагч хуулийн төсөл	Хэрэгцээ шаардлагын тандан судалгаа	Судалгаа хийгдсэн	7	23%
			Судалгаа хийгдээгүй эсхүл	3	10%

⁸ Монгол Улсын Их Хурал <https://d.parliament.mn/>

			нийтэд болгоогүй	ил	
2	Хуулийн шинэчилсэн найруулгын төсөл	Хэрэгцээ шаардлагын тандан судалгаа	Судалгаа хийгдсэн	3	10%
		Хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ	Судалгаа хийгдсэн	4	13%
		Аль аль нь хийгдсэн		3	10%
		Судалгаа хийгдээгүй эсхүл хийтэд ил олгоогүй		1	3%
3	Хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	Хэрэгцээ шаардлагын тандан судалгаа	Судалгаа хийгдсэн	8	26%
			Судалгаа хийгдээгүй эсхүл нийтэд ил болгоогүй	7	23%
Нийт				30	100%

Судалгаанд хамруулсан 30 хуулийн төслөөс 23 төсөлд үр нөлөөний үнэлгээ хийгдсэн нь нийт төслийн 76.7 хувийг эзэлж байна. Энэ үзүүлэлт нь үр нөлөөний үнэлгээ тодорхой хэмжээнд хийгдэж байгаа боловч бүх төсөлд жигд хэрэгжихгүй байгааг харуулж байна. Үр нөлөөний үнэлгээ хийгдсэн төслүүдийн хувьд ч үнэлгээний агуулга нь зарим тохиолдолд ерөнхий, товч, формаль шинжтэй байх хандлага ажиглагдсан. Тухайлбал, хуулийн төсөл практикт хэрэгжих боломжтой эсэх, бусад хуультай давхардал, хийдэл, зөрчил үүсгэх эсэх, хүний эрхэд үзүүлэх нөлөөлөл, урьдчилан тооцоогүй үр дагаврыг бүрэн тодорхойлсон байдал харилцан адилгүй байна. Зардлын

тооцооллын хувьд нийт 30 хуулийн төслөөс 21 төсөлд зардлын тооцоолол хийгдсэн нь нийт төслийн 70 хувийг эзэлж байна. Энэ нь зардлын тооцоолол хийх шаардлага практикт тодорхой хэмжээнд хэрэгжиж байгааг харуулах боловч үлдсэн 30 хувьд нь зардлын тооцоо хийгдээгүй буюу хангалтгүй тусгагдсан байна. Зардлын тооцоолол хийгдсэн төслүүдийн заримд нь зөвхөн улсын төсөвт үүсэх зардлыг авч үзсэн бөгөөд иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх бодит ачаалал, хэрэгжилтийн зардал, хүний нөөц, цаг хугацаа, зохион байгуулалтын зардлыг бүрэн тооцоогүй байдал ажиглагдсан. Хууль тогтоомжийн тухай хуульд заасан тандан судалгаа, үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцоолол хийх эрх зүйн зохицуулалт байгаа боловч тэдгээрийн хэрэгжилт практикт бүрэн жигд бус байна. Өөрөөр хэлбэл, хуулийн төсөлд шаардлагатай баримт бичгийг хавсаргах хэлбэрийн шаардлага тодорхой хэмжээнд биелж байгаа боловч уг баримт бичгийн чанар, бодит үндэслэл, тооцооллын нарийвчлал, хэрэгжилтийн үр дагаврыг тооцсон байдал хангалтгүй байна.

2.7 Монгол улсын хууль тогтоомж, эрх зүйн зохицуулалтын зардлын тооцоо

Монгол улсын “Хууль тогтоомжийн тухай” хуулийн 8 дугаар зүйлд хууль тогтоомжийн төслийг боловсруулах үйл явцаас өмнө ерөнхий байдлаар зардлыг тооцоог хийхээр тусгасан ба тухайн аргачлалыг 12.1.4-т зааснаар засгийн газраас баталж мөрдүүлэхээр үүрэг болгон тусгасан байна. Мөн ХТтХ-ийн 18.1-т зааснаар хууль тогтоомжийн төсөл батлагдсанаар тухайн хуулийн үйлчлэлийн хүрээнд иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад үүсэж болох зардлыг тухай бүрд тооцоолон гаргаж зардал үр өгөөжийн харьцааг тодорхойлох ба хууль тогтоомжийн төслийн бүрдүүлбэр болон тухайн төслийг хэлэлцүүлэх шатанд хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцооллын баримт бичгийг хавсаргана хэмээн заасан нь зардлын тооцоолол зайлшгүй байх шаардлагатай хэмээн үзэж болохоор байна.

“Шүүх байгуулах тухай” шинэчилсэн найруулгын 1 дүгээр зүйлийн гурав дах хэсэгт “Гэр бүл, хүүхдийн хэргийн давж заалдах шатны шүүх”, 2 дугаар зүйлийн дөрөв дэх хэсэгт “Нийслэл дэх Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатны тойргийн шүүх” байгуулахаар заасан байна. Тухайн заалт нь 2026 оны 1 сарын 1-нээс үйлчилж эхлэхээр зохицуулсан бөгөөд Шүүх байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулгын зардлын тооцооны судалгаанд шүүхийн барилга байгууламж, тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, ажилчдын цалин хөлс, тээврийн хэрэгсэл, нийгмийн даатгал зэрэг зардал дээр үндэслэн тооцоолол хийсэн байсан.

үүсэх боломжтой. Ийм зардлыг тусгайлан тооцоогүй бол гэр бүл, хүүхдийн хэргийн дагнасан шүүх байгуулах зорилго бүрэн хэрэгжихэд хүндрэл үүсэж болзошгүй. Зардлын тооцоолол нь зөвхөн төрийн байгууллагын шууд зардалд төвлөрсөн байна. Харин уг зохицуулалт хэрэгжсэнээр иргэн, хүүхэд, гэр бүл, өмгөөлөгч, прокурор, нийгмийн ажилтан, хүүхэд хамгааллын байгууллага зэрэг бусад оролцогчид ямар зардал, цаг хугацааны ачаалал, үйлчилгээний хүртээмжийн өөрчлөлттэй тулгарахыг үнэлсэн эсэх тодорхойгүй байна. Хуулийн төслийн үр нөлөө, зардлын тооцоолол нь зөвхөн төсвийн зардлаар хязгаарлагдахгүй, хэрэгжилтэд оролцох бусад этгээдийн бодит ачааллыг мөн харгалзах шаардлагатай.

Шүүх байгуулах тухай /шинэчилсэн найруулга/ нь 2024 оны 06 сарын 05-ны өдөр батлагдаж 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн. Тухайн хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээний тайланд шалгуур үзүүлэлтээр ойлгомжтой байдал, харилцан уялдаа гэсэн шалгуур үзүүлэлтийг сонгосон байна.

Шалгах хэсгийн хүрээнд Хууль тогтоомжийн тухай хуулийн 22 дугаар зүйлд заасан “Хууль тогтоомжийн төслийн эх бичвэрийн агуулгад тавигдах шаардлага” ХТТХ-ийн 29.2-т “Хуулийн төсөлд шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлага, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, хэсэг, заалтыг хүчингүй болсонд тооцох, зарим үг, өгүүлбэр, тоо, тэмдэгт хасах талаар тусгана.” Гэсэн заалтад үнэлгээ хийхэд “Хуулийн төсөлтэй холбогдуулан хүний нөөц, барилга байгууламж, төсөв хөрөнгөтэй холбоотой зардал гарахаар байгааг анхаарч батлагдсаны дараа хэрэгжих хугацааг боломжтойгоор тооцох нь зүйтэй гэж үзэв.” Гэсэн байх ба дараах нь хэрэгжих эхлэх хугацаанаас өмнө барилга байгууламж, хөрөнгө төсөвтэй холбоотой зардлыг тооцож хэрэгжүүлнэ гэсэн утгыг илэрхийлж байна.

III. БҮЛЭГ. ХАРЬЦУУЛСАН СУДАЛГААНЫ ХЭСЭГ

3.1 Монгол улсын хуулийн төсөл боловсруулах аргачлал

Энэхүү харьцуулсан судалгаа нь Монгол Улсын Хууль тогтоомжийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлд заасан хуулийн төсөл боловсруулах үе шатуудыг Австрали Улсын, Бүгд Найрамдах Солонгос Улс (БНСУ), Федератив Бүгд Найрамдах Герман Улсын (ФБНГУ) тогтолцоотой харьцуулан судалж, тэдгээрийн ижил болон ялгаатай тал, давуу болон сул тал, Монгол Улсад хэрэглэж болох сургамжийг тодорхойлоход чиглэгдсэн болно.

Хүснэгт 3.1. Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг судлах аргачлал

Хуулийн зүйл заалт	Үе шат	Агуулга
8.1.1	Тандан судлал /Үнэлгээ	Хуулийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах, эсвэл хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх (ХТтХ-ийн 13-д заасны дагуу), (51-р зүйлд заасны дагуу үр дагаврын үнэлгээ)
13-р зүйл	Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах	13.2.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуульд нийцэх эсэхийг судлах; 13.2.2.тухайн асуудлыг хууль тогтоомжоор зохицуулах шаардлагатай эсэхийг тодорхойлох; 13.2.3.тухайн асуудлыг зохицуулах эрх зүйн хэм хэмжээг тодорхойлох; 13.2.4.зохицуулах эрх зүйн хэм хэмжээний эерэг болон сөрөг талыг харьцуулан судлах; 13.2.5.хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг урьдчилан тооцсоны үндсэн дээр тухайн асуудлыг шийдвэрлэх үр дүнтэй хувилбарыг тодорхойлох; 13.2.6.шаардлагатай тохиолдолд тухайн асуудлаар гадаад улсын хууль тогтоомжийн зохицуулалтын талаарх харьцуулсан судалгааг үндэсний эрх зүйн тогтолцооны онцлог, хөгжлийн чиг хандлагыг харгалзан оновчтой

		хувилбарыг үндэслэлийн хамт санал болгох зарчмыг баримтлан хийх.
51-р зүйл	Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ	Хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуульд өөрчлөлт оруулах, шинэчлэн найруулах, багц хуулийн төсөл боловсруулахад түүний хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийж, гарч байгаа хүндрэл, бэрхшээл, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлж, цаашид тухайн хууль тогтоомжийг зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлно. Үнэлгээ хийх үе шат: 1. Төлөвлөх 2. Хэрэгжүүлэх 3. Үнэлэх Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд дээрх хугацаанаас өмнө хийж болно.
8.1.2	Үзэл баримтлал боловсруулах	Хуулийн төслийн баримтлалын төслийг боловсруулах (ХТТХ-ийн 14, 15-д заасны дагуу)
14-р зүйл	Үзэл баримтлалын төсөлд дараах асуудлыг тусгана.	14.2.1.хууль тогтоомжийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага; 14.2.2.хууль тогтоомжийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ; 14.2.3.хууль тогтоомж батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал; 14.2.4.хууль тогтоомжийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, шинэчлэн найруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй

		болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал.
8.1.3	Төсөл боловсруулах	Хууль тогтоомжийн төслийг боловсруулах (ХТтХ-ийн 16-д заасны дагуу)
8.1.4	Үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцоолол	Хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцооллыг хийх (ХТтХ-ийн 17,18-д заасны дагуу)
17-р зүйл	Үр нөлөөг үнэлэх	17.2.1.хууль тогтоомжийн төсөл, эсхүл түүний зарим зүйл, заалтын зохицуулалтын практикт хэрэгжих боломж, харилцан уялдаа зэргийг тооцож шинжилгээ хийх; 17.2.2.хууль тогтоомжийн төслийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах; 17.2.3.хууль тогтоомжийн төслийг батлан хэрэгжүүлснээр үүсэж болзошгүй, урьдчилан тооцоогүй үр дагаврыг тодорхойлох. 17.2.4.хууль тогтоомжийн төслийн хүний эрхэд нөлөөлөх байдлыг үнэлэх.
18-р зүйл	Зардлын тооцоог хийх	18.1.1.хууль тогтоомжийн төслийн улсын төсөвт үзүүлэх нөлөөллийг тооцох; 18.1.2.хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамаарах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлыг тооцох.
8.1.5	Нийтийн хэлэлцүүлэг	Иргэн, хуулийн этгээдийн төлөөлөл, олон нийтээр хэлэлцүүлж санал авах
8.1.6	Байгууллагын санал авах	Төрийн болон ТББ, мэргэжлийн байгууллагын санал авах
8.1.8	УИХ-д өргөн мэдүүлэх	Бүрдүүлбэрийг хангаж, УИХ-д өргөн мэдүүлэх

эх сурвалж: Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем legalinfo.mn

3.2 Австрали Улсын хуулийн төсөл боловсруулах үе шат

Австрали Улсын тогтолцоо

Австралийн Парламент нь Хаан (Генерал Засаг даргын төлөөлөл) болон хоёр танхим (Сенат болон Төлөөлөгчийн танхим)-аас бүрддэг. Австралийн холбооны хуулийн боловсруулах тогтолцоо нь Ерөнхий сайдын болон Кабинетийн газрын (Department of the Prime Minister and Cabinet — PM&C) удирдлага дор явагддаг. Австралийн холбооны хуулийн тогтоомжийн гол онцлог нь Парламентын Зөвлөх Газар (Office of Parliamentary Counsel — OPC)-ийн үүрэг байдаг. OPC нь хуулийн бичгийн ажлыг мэргэжлийн удирдлагаар гүйцэтгэдэг бөгөөд дотоодын болон олон улсын хуулийн жишигт нийцсэн хуулийн найруулгыг боловсруулдаг.

Австрали улс нь хуулийн төсөл боловсруулах тусгай гарын авлагатай бөгөөд хуулийн бүтцийн хувьд ерөнхий хэсэг, тусгай хэсэг гэж хуваадаг. Ерөнхий хэсэгт хуулийн ерөнхий зохицуулалтыг оруулдаг. Өөрөөр хэлбэл, хууль ямар нөхцөлд хэрэгжих, ямар нэр томьёо хэрэглэх, хууль зүйн үндсэн суурь нь юу байх зэрэг нийтлэг зүйлсийг энэ хэсэгт тусгадаг. Харин тусгай хэсэгт тухайн хуультай холбоотой тодорхой асуудал, журам болон нарийвчилсан зохицуулалтыг оруулдаг. Австрали улс нь хууль тогтоомж боловсруулах үйл явцын гарын авлага (Guide to the legislation process) ашигладаг.

Хүснэгт 3.2. Австрали улсын хуулийн төсөл боловсруулах үе шат

Алхам 1.	Бодлогыг эцэслэн тодорхойлох Энэ алхамд тухайн яам, агентлаг шинэ бодлого, санаачилгын үндсэн агуулгыг боловсруулна. Бодлогын зорилго, хүрэх үр дүн, хэрэгжүүлэх арга зам, хэрэгжилтийн үе шат, оролцох байгууллагууд, санхүүжилт, хүний нөөц, зохион байгуулалтын хэрэгцээг тодорхойлно.
Алхам 2.	Бодлогын талаар зөвлөлдөх Яам, агентлаг бодлогын саналын талаар холбогдох оролцогч талуудтай зөвлөлдөнө. Зөвлөлдөх этгээдэд тухайн асуудлыг хариуцсан сайд, салбарын мэргэжлийн болон төлөөллийн байгууллага, зохицуулагч байгууллага, PM&C-ийн холбогдох бодлогын багууд, тухайн бодлогод өртөж болзошгүй бусад яам, агентлаг, сайд нар хамаарна. Зөвлөлдөөний зорилго нь бодлогын саналын үр дагаврыг урьдчилан тодорхойлох, бодлогын хэрэгжилтэд тулгарч болох хүндрэл, давхардал, зөрчил, нөөцийн шаардлага, эрх зүйн эрсдэлийг илрүүлэх явдал юм.

Алхам 3.	Хууль тогтоомжийн шаардлагыг тодорхойлно • Яам, агентлаг бодлогын зорилтуудаас аль нь зөвхөн анхдагч хууль тогтоомжийн замаар хэрэгжих боломжтойг үнэлнэ. Энэ хүрээнд хууль зүйн зөвлөх болон Office of Impact Analysis буюу Нөлөөллийн шинжилгээний газраас мэргэжлийн зөвлөгөө авна. Хууль зүйн зөвлөх нь тухайн асуудлыг хууль тогтоомжоор зохицуулах шаардлага, Үндсэн хууль болон бусад хуультай нийцэх эсэхийг үнэлнэ. Харин Нөлөөллийн шинжилгээний газар нь тухайн бодлогын саналын үр нөлөө, зардал, хэрэгжилтийн боломж, хувилбаруудын талаар зөвлөгөө өгнө.
Алхам 4.	Бодлогын нарийвчлагдсан агуулга эцэслэгдсэн эсэхийг шалгах • Энэ алхамд яам, агентлаг бодлогын агуулга хуулийн төсөл боловсруулахад хангалттай хэмжээнд боловсорсон эсэхийг үнэлнэ. Хэрэв бодлогын гол асуудлууд шийдэгдээгүй, хэрэгжилтийн механизм тодорхой бус, оролцогч талуудын санал бүрэн тусгагдаагүй, эсхүл хууль зүйн асуудал нээлттэй хэвээр байвал бодлогын боловсруулалтыг үргэлжлүүлж, Алхам 1 рүү буцна. Харин бодлогын зорилго, хэрэгжилтийн арга, хамрах хүрээ, эрх зүйн үндэслэл, хэрэгжүүлэх байгууллага, оролцогч талуудын байр суурь хангалттай тодорхой болсон бол бодлогын зөвшөөрөл авах шат руу шилжинэ.
Алхам 5.	Бодлогын зөвшөөрөл авах • Энэ алхамд тухайн бодлого Засгийн газрын холбогдох түвшинд албан ёсоор зөвшөөрөгдөнө. Яам, агентлаг PM&C-ийн холбогдох бодлогын багуудтай зөвлөлдөж, тухайн бодлогод ямар төрлийн зөвшөөрөл шаардлагатайг тодорхойлно.
Алхам 6.	Хуулийн төсөл боловсруулах заавар бэлтгэх • Бодлогын зөвшөөрөл авсны дараа яам, агентлаг Office of Parliamentary Counsel (OPC)-д зориулан хуулийн төсөл боловсруулах дэлгэрэнгүй заавар бэлтгэнэ. Энэхүү заавар нь хуулийн төслийн бодлогын зорилго, зохицуулах харилцаа, хамрах этгээд, хэрэгжүүлэх механизм, эрх, үүрэг, хориг,

	зөвшөөрөл, хяналт, хариуцлага, шилжилтийн зохицуулалт зэрэг бүх гол асуудлыг тодорхой тайлбарласан байх ёстой.
Алхам 7.	Хүсэлт бэлтгэх • Тухайн төслийг хууль тогтоомжийн хөтөлбөрт оруулах тухай Ерөнхий сайдад хандах баримт бичгийн төслийг бэлтгэнэ. Уг бичигт хуулийн төслүүд болон тэдгээрийн ангиллыг тусгах бөгөөд тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлдэг. - Т ангилал нь парламентийн нэг хуралдааны хугацаанд өргөн мэдүүлж, батлуулах шаардлагатай цаг хугацааны хувьд нэн яаралтай хуулийн төсөл - А ангилал нь өндөр тэргүүлэх ач холбогдолтой - В ангилал нь дунд зэргийн - С ангилал нь харьцангуй бага тэргүүлэлтэй хуулийн төсөлд харгалзана. Яамны Хууль тогтоомжийн асуудал хариуцсан ажилтан (Legislation Liaison Officer) нь хүсэлтийн баримт бичгийн төслийг албан ёсоор хүргүүлэхээс өмнө санал авах зорилгоор PM&C-гийн хууль тогтоомжийн хэлтэст хүргүүлнэ.
Алхам 8.	Хүсэлтийг хүргүүлэх • Хуулийн төслийг хууль тогтоомжийн хөтөлбөрт оруулах хүсэлтийг Ерөнхий сайдад албан ёсоор хүргүүлнэ. Алхам 7-д хууль тогтоомжийн асуудал хариуцсан ажилтан төслийг хянан үзүүлснээс хойш гаргасан аливаа өөрчлөлтийн талаар PM&C хууль тогтоомжийн хэлтэст мэдэгдэнэ.
Алхам 9.	PM&C болон Парламентын Зөвлөхүүдийн Газар төслүүдийг хянана • PM&C-ийн бодлогын багуудтай зөвлөлдсөний дараа PM&C-ийн хууль тогтоомжийн хэсэг нь Парламентийн хууль боловсруулах албатай уулзаж, Засгийн газрын хэмжээнд ирүүлсэн хүсэлтүүдийг хянана.
Алхам 10.	Хүлээгдэж буй төслийг боловсруулах зааврыг гаргах

	6-р алхамд бэлтгэсэн төслийн үлдсэн бүх төсөл боловсруулах зааврыг, мөн бодлого батлагдсан болохыг нотлох баримтын хамт Парламентийн хууль боловсруулах албанд хүргүүлнэ.
Алхам 11.	Парламентийн Бизнесийн хороо хууль тогтоомжийн хөтөлбөрийг тогтоох Хууль тогтоомж бүрийг засгийн газрын тэргүүлэх чиглэлүүдтэй харьцуулж, зохих ангиллыг хуваарилдаг. Хууль тогтоомжийн эцсийн хөтөлбөрийг Засгийн газрын тэмдэглэлд тэмдэглэж, Засгийн газрын холбогдох албан тушаалтнуудад хүргүүлдэг.
Алхам 12.	Парламентийн хууль боловсруулах алба хуулийн төслийг боловсруулах Парламентийн хууль боловсруулах албаны хууль боловсруулагч нь яам, агентлагуудаас ирүүлсэн зааврыг хянаж, түүнд үндэслэн хуулийн төслийг боловсруулдаг. Хэрэв хуулийн төсөл эцэслэгдээгүй бөгөөд төслийг цаашид хянах шаардлагатай бол Алхам 13 руу шилжинэ. Хэрэв хуулийн төслийн нарийвчилсан агуулга эцэслэгдсэн бол Алхам 14 рүү шилжинэ.
Алхам 13.	Хянах ба нэмэлт заавар өгөх Хуулийн төслийг хянаж, тодруулга, санал, шаардлагатай бусад дэмжлэгийг Парламентийн хууль боловсруулах албийн төсөл боловсруулагчид өгнө. Хуулийн төслийн хувилбар бүрд ОРС-ийн хууль боловсруулагчаас тавьсан бүх асуултад хариулт өгөх үүрэгтэй. Яам, агентлаг нь санал болон нэмэлт зааврыг шуурхай өгөх, эсхүл хариу өгөхөд саатал гарах магадлалтай бол ОРС-д мэдэгдэх ёстой. Дараа нь Алхам 12 руу буцна.
Алхам 14.	Хуулийн төслийн талаар гадаад зөвлөлдөөн шаардлагатай эсэх Хэрэв сайд гадаад зөвлөлдөөн шаардлагатай гэж үзсэн, эсхүл гадаад зөвлөлдөөн заавал хийх шаардлагатай бол Алхам 15 руу шилжинэ. Үгүй бол Алхам 19 рүү шилжинэ.
Алхам 15.	Парламентын хууль боловсруулах алба нийтийн хэлэлцүүлгийн төсөл бэлтгэх. Тус яам нь хуулийн төслийн нэмэлт төслийг бэлтгэхийн тулд ОРС-тэй хамтран ажиллаж байна.
Алхам 16.	Нийтийн хэлэлцүүлгийн төслийг нийтлэх зөвшөөрөл авах

	Сайд нийтийн хэлэлцүүлгийн төслийг нийтлэх талаар Засгийн газар, эсхүл Ерөнхий сайдын зөвшөөрлийг хүснэ. Парламентад хараахан өргөн мэдүүлээгүй хууль тогтоомжийн талаар олон нийтэд мэдэгдэл хийхэд мөн Кабинет, эсхүл Ерөнхий сайдын зөвшөөрөл шаардлагатай. Зөвшөөрөл авсны дараа Алхам 17 руу шилжинэ.
Алхам 17.	Нийтийн хэлэлцүүлгийн төслийн талаар зөвлөлдөх Яам, агентлаг нь нийтийн хэлэлцүүлгийн төслийн талаар зөвлөлдөөн хийж болно. Үүнд хэрэгжилтийн нарийвчилсан асуудлаар салбарын төлөөллийн байгууллага болон зохицуулагчтай зөвлөлдөх, мөн нөлөөлөл, эсхүл ойлгомжтой байдлын талаар олон нийтийн зөвлөлдөөн хийх ажиллагаа багтаж болно.
Алхам 18.	Зөвлөлдөөн хуулийн төсөлд өөрчлөлт оруулахад хүргэсэн эсэх Хэрэв өөрчлөлт оруулах болсон бөгөөд тухайн өөрчлөлт нь одоогийн бодлогын эрх мэдлийн хүрээнд хамаарах бол Алхам 13 руу буцна. Хэрэв одоогийн бодлогын эрх мэдлийн хүрээнээс давсан бол шинэ бодлогын зөвшөөрөл аван Алхам 13 руу буцна. Өөрчлөлт оруулах шаардлагагүй тохиолдолд Алхам 17 руу шилжинэ.
Алхам 19.	Дагалдах материалыг эцэслэн боловсруулсан эсэх Тайлбар санамж бичиг болон хоёр дахь хэлэлцүүлгийн дүгнэлт зэрэг дагалдах баримт бичгийг бэлтгэсэн эсэхийг баталгаажуулна.
Алхам 20.	Хуулийн төслийг өргөн мэдүүлэх үйл явц Хуулийн төсөл орох чуулганы ээлжийн өмнөх долоо хоногт тогтсон хугацааны дэглэм мөрдөгдөнө: Лхагва гарагийн 11:00 цагаас өмнө яамны LLO нь тайлбар тэмдэглэл болон нэмэлт сайдын зөвшөөрлийн нотолгоог PM&C Хууль тогтоомжийн хэлтэст хүргүүлнэ; OPC нь хуулийн төслийг ижил хугацаанд хүргүүлнэ. Баасан гарагийн 11:00 цагаас өмнө яам нь сайдын текстийн эцсийн зөвшөөрлийг баталгаажуулах и-мэйл илгээнэ. Уг хатуу хугацааны дэглэм нь Хууль тогтоомжийн зөвшөөрлийн үйл явцын эмх цэгцтэй явагдахыг хангах зорилготой.

Алхам 21.	Нэмэлт материал болон эцсийн эх бичвэрийг батлах Сайд хуулийн төсөл болон тайлбар санамж бичгийн эцсийн эх бичвэр, дагалдах материалыг батална.
Алхам 22.	Хууль тогтоомжийг батлах үйл явц Чуулганы долоо хоногийн хугацаанд хуулийн төсөл болон тайлбар тэмдэглэл нь Хууль тогтоох батлах үйл явцаар дамждаг: - Хууль тогтоох хэсэг болон Парламентын нэгдүгээр зөвлөх Хууль тогтоох сайдад мэдээлэл өгнө. - Хууль зүйн сайд хуулийн төслийг хянаж, өргөн барихаар батална. - Засгийн газрын намын танхим хуралдах үед уг хуулийн төслийг баталдаг.
Алхам 23.	Хуулийн төслийг парламентад танилцуулах Хуулийн төслийг парламентад өргөн мэдүүлнэ. Энэ нь эхний үе шат бөгөөд хоёр дах үе шатанд гишүүд хуулийн төсөлд туссан үндсэн санааны талаар хэлэлцэж санал хураалт явагдана. Тус хэлэлцүүлэгт нэгээс дээш зөвлөх байлцах ёстой бөгөөд эдгээр зөвлөхүүд нь хууль тогтоомжийн талаар дэлгэрэнгүй мэдлэгтэй байх бөгөөд хариулт, санал гаргах эрхтэй этгээд байна. Гуравдугаар хэлэлцүүлгээр эцсийн санал хураалт явагдана. Хуулийн төсөл хоёр танхимаар батлагдвал Ерөнхий амбан захирагчид хүргүүлж 8-10 хоногийн дотор хааны зөвшөөрөл олгогдсоноор Парламентын хууль батлагдана.

Эх сурвалж: Австралийн Засгийн газрын Ерөнхий сайд ба Засгийн газрын хэрэг эрхлэх газар цахим

хуудас: <https://www.pmc.gov.au/>.

6.3 Бүгд Найрамдах Солонгос Улсын хуулийн төсөл боловсруулах үе шат

Бүгд Найрамдах Солонгос Улсын тогтолцоо

Бүгд Найрамдах Солонгос Улс нь ерөнхийлөгчийн засаглалтай, нэг танхимт Үндэсний Ассамблейтай (국회, National Assembly) улс юм. Хуулийн төсөл нь Үндэсний Ассамблейн гишүүдийн санаачилгаар, эсхүл Засгийн газрын санаачилгаар өргөн мэдүүлэгдэх боломжтой. Үндэсний Ассамблейн гишүүний санаачилсан хуулийн төсөлд 10 ба түүнээс дээш гишүүний дэмжлэг шаардагддаг. Засгийн газрын санаачилсан хуулийн төслийн хувьд Ministry of Government Legislation (법제처, MOLEG) нь хууль тогтоомжийн хэлбэр, нэр томъёо, найруулгын систем, бодит хэрэгцээ, төрийн бодлогын

зорилготой нийцэл болон дээд шатны хууль тогтоомжтой зөрчилдөх эсэхийг шалгадаг. Иймээс MOLEG нь БНСУ-ын Засгийн газрын хууль тогтоомж боловсруулах ажиллагаанд хуулийн чанарыг хангах төв байгууллагын үүрэг гүйцэтгэдэг.

Хүснэгт 3.3. *Бүгд Найрамдах Солонгос Улсын хууль тогтоох үе шат*

Алхам 1.	Хууль тогтоох төлөвлөгөө боловсруулах Хууль тогтоомжийн газрын дарга жил бүр Засгийн газрын хууль тогтоомжийн төлөвлөгөө боловсруулах удирдамжийг батлан, өмнөх оны 10 дугаар сарын 31-ний өдрөөс өмнө төв захиргааны байгууллагын дарга нарт хүргүүлнэ. Төв захиргааны байгууллагын дарга нар тухайн жилийн хууль тогтоомжийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, хууль тогтоомжийн төсөл тус бүрээр хууль батлах шаардлага, үндсэн агуулга, хэрэгжүүлэх хуваарь, хууль тогтоомж батлагдсанаар үүсэж болзошгүй асуудал зэргийг тусгасан хууль тогтоомжийн төлөвлөгөөг боловсруулан өмнөх оны 11 дүгээр сарын 30-ны өдрөөс өмнө Хууль тогтоомжийн газарт хүргүүлнэ. Ирүүлсэн хууль тогтоомжийн төлөвлөгөөнүүдийг Хууль тогтоомжийн газрын дарга Засгийн газрын нийт түвшинд хууль тогтоомжийн хэрэгжилтийн хуваарь, давхардал, зөрчилдөөнтэй асуудлыг хянан зохицуулсны дараа жил бүрийн 1 дүгээр сард Төрийн зөвлөлийн хуралдаанд тайлагнана. Үүний дараа төлөвлөгөөний агуулгыг албан ёсны хэвлэлд нийтэлж, цахим сүлжээ зэрэг арга хэрэгслээр олон нийтэд мэдээлнэ.
Алхам 2.	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах Тухайн бодлогыг хэрэгжүүлэхэд хууль тогтоомж шаардлагатай гэж үзвэл тухайн бодлогыг хариуцсан төв захиргааны байгууллага өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хууль тогтоомжийн төслийг боловсруулдаг.
Алхам 3.	Холбогдох байгууллагуудтай зөвлөлдөх Хууль тогтоомжийн төслийн хариуцсан байгууллага нь төслийг боловсруулсны дараа холбоотойгоор үүсэж болзошгүй эрсдэлийг урьдчилан зохицуулах зорилгоор төслийн агуулгатай холбоотой холбогдох байгууллагуудтай зөвлөлдөх ажиллагаа явуулна. Холбогдох байгууллагуудтай зөвлөлдөх хугацаа 10-аас доошгүй хоног байна. Харин хууль тогтоомжийн төслийг яаралтай

	хэрэгжүүлэх шаардлага үүссэн зэрэг онцгой нөхцөл байгаа бол Хууль тогтоомжийн газрын даргатай зөвшилцөн уг хугацааг 10 хоногоос бага болгон богиносгож болно.
Алхам 4.	Урьдчилсан нөлөөллийн үнэлгээ - Захиргааны байгууллага хууль тогтоомжийг шинээр батлах эсхүл нэмэлт, өөрчлөлт оруулах үед тухайн зохицуулалттай холбоотойгоор үүсэж болзошгүй эрсдэл, нөлөөллийг иж бүрэн байдлаар шинжилж үнэлдэг. Урьдчилсан нөлөөллийн үнэлгээ нь тус тусын хуульд үндэслэнэ. Үүнд: “Авлигаас урьдчилан сэргийлэх болон Иргэдийн эрх ашгийг хамгаалах комиссын байгуулалт, үйл ажиллагааны тухай хууль”-д үндэслэсэн авлигын нөлөөллийн үнэлгээ; “Жендерийн нөлөөллийн үнэлгээний тухай хууль”-д үндэслэсэн жендерийн нөлөөллийн үнэлгээ; “Орон нутгийн их сургууль болон бүс нутгийн тэнцвэртэй хүний нөөцийг хөгжүүлэх тухай хууль”-д үндэслэсэн бүс нутгийн тэнцвэртэй хүний нөөцийн ажил эрхлэлтийн нөлөөллийн үнэлгээ; “Хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль”-д үндэслэсэн хувийн мэдээлэлд халдах хүчин зүйлийн үнэлгээ; “Статистикийн тухай хууль”-д үндэслэсэн статистикт суурилсан бодлогын үнэлгээ; “Орон нутгийн өөрөө удирдах тухай хуулийн хэрэгжүүлэх журам”-д үндэслэсэн орон нутгийн өөрөө удирдах, төвлөрлийг сааруулах урьдчилсан зөвшилцөл тус тус хамаарна.
Алхам 5.	Хууль тогтоомжийн төслийг урьдчилан нийтэд мэдээлэх Хууль тогтоомжийн төслийг урьдчилан нийтэд мэдээлэх нь шинэ хууль батлах, өөрчлөх, хүчингүй болгох үед төслийг олон нийтэд танилцуулж, иргэдийн саналыг авч тусгах зорилготой бөгөөд хууль тогтоох үйл явцын ил тод байдал, үр нөлөөг нэмэгдүүлэхэд чиглэнэ. Төслийн үндсэн агуулга, санал авах хугацаа, хэлбэрийг албан ёсоор нийтэлж, шаардлагатай бол бусад мэдээллийн хэрэгслээр түгээнэ. Урьдчилан мэдээлэх хугацаа ерөнхийдөө 40-өөс доошгүй хоног байх бөгөөд тодорхой нөхцөлд хугацааг богиносгож эсхүл мэдээлэхгүй байж болно.

Алхам 6.	Зохицуулалтын хяналт Хууль тогтоомжийн төслийг хариуцсан байгууллагын дарга нь шинэ зохицуулалт бий болгох, эсхүл одоо мөрдөж буй зохицуулалтыг чангатгах агуулгатай хуулийн төсөл боловсруулах тохиолдолд уг төслийг Хууль тогтоомжийн газарт хянуулахаар хүргүүлэхээс өмнө холбогдох материалыг бүрдүүлнэ. Үүнд зохицуулалтын нөлөөллийн шинжилгээний тайлан, дотоод хяналтын санал зэргийг хавсаргаж, Зохицуулалтын шинэчлэлийн хороогоор зохицуулалтын хяналт хийлгэнэ.
Алхам 7.	Хууль тогтоомжийн газрын хяналт Хууль тогтоомжийн газар нь Ерөнхий сайдын харьяанд байгуулагдсан төв захиргааны байгууллага бөгөөд Засгийн газрын хууль тогтоомжийн ажлыг төлөвлөх, зохицуулах, төслийг хянах, тайлбарлах, боловсронгуй болгох зэрэг нэгдсэн удирдлагын чиг үүргийг хэрэгжүүлдэг. Хуулийн төслийг хариуцсан байгууллага эх хувилбарыг эцэслэсний дараа Хууль тогтоомжийн газарт хянуулж, уг газар нь төслийн хэлбэр (үг хэллэг, бүтэц)-ээс гадна Үндсэн хууль болон бусад хуульд нийцэж байгаа эсэх, зөрчил, давхардал байгаа эсэхийг шалган сайжруулдаг. Мөн төслүүдийг хамтарсан хяналтын хуралдаанаар хэлэлцэж, илүү бүрэн дүгнэлт гаргадаг. Энэ хяналтын тогтолцоо нь хууль тогтоомжийг батлахаас өмнө эрх зүйн зөрчил, зохисгүй зохицуулалтаас урьдчилан сэргийлэхэд чиглэдэг.
Алхам 8.	Дэд сайд нарын хурал болон Төрийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх Засгийн газрын хууль тогтоомжийн яам хуулийн төслүүд болон ерөнхийлөгчийн зарлигуудыг хянаж дуусмагц хуулийн төслүүдийг Дэд сайд нарын уулзалт болон Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэнэ. Дэд сайд нарын уулзалт нь Засгийн газрын хуралдаанд оруулах хэлэлцэх асуудлын чухал асуудлуудыг урьдчилан хэлэлцэх үүргийг гүйцэтгэдэг; гэхдээ яаралтай тохиолдолд Дэд сайд нарын уулзалтыг орхигдуулж, хуулийн төслүүдийг Засгийн газрын хуралдаанд шууд хэлэлцүүлэхээр оруулж болно.
Алхам 9.	Ерөнхийлөгчийн зөвшөөрөл болон Ерөнхий сайд, холбогдох Төрийн зөвлөлийн гишүүдийн хамтран баталгаажуулалт

	Засгийн газрын хэлэлцсэн хуулийн төслүүд (хуулийн төслүүд болон ерөнхийлөгчийн зарлигууд)-д Ерөнхий сайд болон холбогдох Засгийн газрын гишүүд гарын үсэг зурж, Ерөнхийлөгч батална.
Алхам 10.	Үндэсний Ассамблейд өргөн мэдүүлэх Ерөнхийлөгчийн баталсан хуулийн төслүүдийг Засгийн газрын Хууль тогтоох яам Ерөнхийлөгчийн нэрийн өмнөөс Үндэсний чуулганаар нэн даруй өргөн барьдаг.
Алхам 11.	Үндэсний Ассамблейгаар хэлэлцэж, батлах Засгийн газраас өргөн барьсан хуулийн төслийг Улсын Их Хурлын дарга нэгдсэн хуралдаанд танилцуулсны дараа холбогдох байнгын хороонд шилжүүлж, хороо нь хэлэлцэн хянана. Шаардлагатай тохиолдолд олон нийтийн сонсгол зохион байгуулж болно. Дараа нь төслийг Хууль тогтоомж, шүүхийн хороогоор үг хэллэг, бүтцийн хувьд нягталж, эцэслэн боловсруулсны дараа нэгдсэн хуралдаанд дахин оруулдаг.
Алхам 12.	Нийтлэх хуулийн төслийг засгийн газарт шилжүүлэх Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанаар батлагдсан хуулийн төслүүдийг Засгийн газарт өргөн мэдүүлдэг.
Алхам 13.	Засгийн газрын хуралдаанд өргөн мэдүүлэх Засгийн газарт хуулийн төслийг шилжүүлэхдээ холбогдох яам нь хэлэлцэх асуудлын жагсаалт боловсруулах удирдамжийн дагуу төслийг боловсруулж Засгийн газарт өргөн мэдүүлнэ. Хэлэлцүүлэг дууссаны дараа Ерөнхий сайд болон холбогдох гишүүд гарын үсэг зурж, Ерөнхийлөгч батална. Харин Ерөнхийлөгч эсэргүүцэлтэй бол 15 хоногийн дотор бичгээр буцааж, дахин хэлэлцүүлэх хүсэлт гаргаж болно. Дахин хэлэлцсэн төслийг нийт гишүүдийн олонхын ирцтэй, оролцсон гишүүдийн гуравны хоёрын саналаар дахин баталбал хууль эцэслэн батлагдаж, Ерөнхийлөгч Засгийн газарт шилжүүлсний дараа нэн даруй нийтэлнэ.
Алхам 14.	Нийтлэх Хуулийн төслийг Үндэсний Ассамблейгаас Засгийн газарт шилжүүлж, хэлэлцүүлсний дараа Ерөнхийлөгчийн зөвшөөрөл авна. Энэ үед Засгийн газрын Хууль тогтоомжийн яам тухайн

	хууль болон Ерөнхийлөгчийн зарлигт батлах дугаар олгож, Албан ёсны сонинд нийтлүүлэхийг хүсэлт гарган олон нийтэд мэдээлнэ. Албан ёсны сонинд нийтлэгдсэнээр хууль болон Ерөнхийлөгчийн зарлиг хүчин төгөлдөр болно. Мөн сайдын болон Ерөнхий сайдын зарлигуудыг хянан дууссаны дараа батлах дугаар олгож, холбогдох журмын дагуу Албан ёсны сонинд нийтлүүлэн нийтэд мэдээлдэг.
--	--

Эх сурвалж: БНСУ-ын Засгийн газрын хууль тогтоомжийн яам цахим хуудас: <https://moleg.go.kr/english/>.

6.4 Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын хуулийн төсөл боловсруулах үе шат

Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын тогтолцоо

Герман Улс нь холбооны, Үндсэн хуульт буюу Grundgesetz-д суурилсан төрийн байгуулалтай улс юм. Холбооны хууль тогтоох ажиллагаанд Bundestag болон холбооны мужуудыг төлөөлөх Bundesrat оролцдог. Засгийн газрын хуулийн төсөл боловсруулах ажиллагаа нь холбооны яамдын нэгдсэн ажлын журам болох Gemeinsame Geschäftsordnung der Bundesministerien (GGO)-оор нарийвчлан зохицуулагддаг. Германы тогтолцооны онцлог нь тэргүүлэх яам (federführendes Bundesministerium) бусад холбогдох яам, Холбооны Канцлерын газар, Холбооны Хууль зүйн яам болон Nationaler Normenkontrollrat (NKR)-тай зөвшилцөх яам хоорондын ажиллагаа юм.

Хүснэгт 3.4. Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын хууль тогтоох үе шат

Алхам 1.	Хуулийн төслийн санаачлах Холбооны Засгийн газар хууль санаачлахдаа эхлээд хуулийн төслийг Холбооны Зөвлөлд өргөн барьж, Зөвлөл ихэвчлэн зургаан долоо хоногийн дотор санал өгнө. Үүний дараа Засгийн газар өөрийн мэдэгдлийн хамт төслийг Бундестагт хүргүүлдэг. Харин төсвийн хуулийн төслийг Холбооны Зөвлөл болон Бундестагт нэгэн зэрэг илгээдэг. Бундесрат (Холбооны мужуудын төлөөллийн байгууллага)-ын санаачилсан төслийн хувьд гишүүдийн олонх дэмжсэний дараа эхлээд Засгийн газарт хүргүүлж, Засгийн газар зургаан долоо хоногийн дотор санал өгөөд Бундестагт (Холбооны Парламент) шилжүүлнэ.
Алхам 2.	Ашиг сонирхол, хэрэгцээ шаардлагыг тодруулах Энэ шатанд тухайн зохицуулалт ямар этгээд, байгууллага, холбооны муж, орон нутгийн эрх ашигт нөлөөлөхийг урьдчилан тодруулна.
Алхам 3.	Хуулийн төслийн бүтэц, үндэслэл, үр дагаврыг боловсруулах

	Тухайн хуулийн төслийн асуудал, зорилго, шийдэл, боломжит хувилбар, төсөвт үзүүлэх нөлөө, хэрэгжилтийн зардал, иргэн, аж ахуй нэгж, захиргаанд үзүүлэх ачаалал зэргийг судална.
Алхам 4.	Холбогдох байгууллагуудыг оролцуулах ба эрх зүйн хяналт хийлгэх Хуулийн төслийг Засгийн газрын шийдвэрт оруулахын өмнө тухайн төслийн нөлөөлөлд өртөх Холбооны яамд болон Үндэсний норм хяналтын зөвлөл-ийг хуульд заасан чиг үүргийн хүрээнд хэлэлцдэг. Мөн Үндсэн хуульд нийцэх эсэх болон эрх зүйн тогтолцоонд зөрчилгүй нийцэх эсэх асуудлаар холбогдох яамдыг оролцуулдаг. Засгийн газрын хуулийн төслийг шийдвэрлүүлэхээр оруулахаас өмнө Холбооны Хууль зүйн яаманд эрх зүйн системчилсэн болон эрх зүйн хэлбэрийн хяналт хийлгэнэ. Энэ нь хуулийн төсөл Үндсэн хууль, эрх зүйн тогтолцоо, хууль найруулгын шаардлагад нийцэж байгаа эсэхийг шалгах шат юм.
Алхам 5.	Кабинетад буюу Холбооны Засгийн газарт хэлэлцүүлэх Кабинетад оруулах материалд тухайн хуульд Бундесратын зөвшөөрөл шаардлагатай эсэх, Хууль зүйн яамны эрх зүйн хяналт хийгдсэн эсэх, хуулийн үр дагаврын шаардлага хангагдсан эсэх, оролцогч байгууллагуудын зөрүүтэй байр суурь, холбоо, муж, орон нутгийн төсөвт гарах зардал, Үндэсний норм хяналтын зөвлөлийн санал гарсан эсэх зэрэг мэдээллийг тусгана. Санхүүгийн үр дагаврыг тайлбарлахдаа тооцоо, таамаглал юунд үндэслэсэн болохыг харуулах ёстой.
Алхам 6.	Батлагдах эх бичвэр бэлтгэх, нийтлэх Хуулийн төсөл парламентын ажиллагаагаар батлагдсаны дараа хууль болгон ёсчлох, албан ёсны эх бичвэр бэлтгэх, нийтлэх ажиллагаа

6.5 Хууль тогтоомжийн төсөл боловсруулах олон улсын туршлага

1. Хууль тогтоомжийн хэрэгцээ шаардлагын тандан судалгаа хийдэг эсэх

Хүснэгт 3.5. Тандан судлал ба үнэлгээ

	Австрали улс	Герман улс	Бүгд Найрамдах Солонгос Улс
Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагын тандан судалгаа	Яам, агентлаг бодлогын зорилтыг хэрэгжүүлэхэд хууль шаардлагатай эсэхийг үнэлж, шаардлагатай бол хууль зүйн зөвлөх болон Office of Impact Analysis-аас зөвлөгөө авдаг.	Германы холбооны хуулийн төсөл боловсруулах эхний шатанд тухайн асуудлыг хариуцсан тэргүүлэх холбооны яам хуулийн төслийн зорилго, шаардлага, үндэслэл болсон нөхцөл байдлыг тодорхойлдог.	Холбогдох яам эрх мэдлийнхээ хүрээнд хуулийн төслийг боловсруулах эхний шатанд асуудлыг тодорхойлж, судалгаа хийдэг. KLRI (Korean Law Information Center)-ийн мэдээллийн дагуу тодорхой аргачлал заавал мөрддөг.

Тухайн гурван улсын хуулийн төсөл боловсруулах үе шатанд хэрэгцээ, шаардлагын тандан судалгаа гэсэн тусгайлсан үе шат байдаггүй ч хуулийн төслийн бодлогыг боловсруулах явцдаа холбогдох байгууллагаас зөвлөгөө аван тухайн бодлогын зорилтыг хэрэгжүүлэх шаардлагатай эсэх талаар тодорхойлдог.

5. Хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалын төсөл хийдэг эсэх

Хүснэгт 3.6. Үзэл баримтлалын төсөл боловсруулах

	Австрали улс	Герман улс	Бүгд Найрамдах Солонгос Улс
Хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалын төсөл	“Үзэл баримтлал” гэсэн тусдаа нэртэй баримт бичиг байхгүй боловч бодлогыг эцэслэх, бодлогын зөвшөөрөл авах, төсөл боловсруулах заавар	Үзэл баримтлал гэсэн тусгай баримт бичиг боловсруулдаггүй ч хууль тогтоомжийн төсөл боловсруулах үе шатын Алхам 3-т хуулийн төслийн	Хууль тогтоомжийн төлөвлөгөө болон хууль тогтоомжийн төсөл боловсруулах үе шатанд хуулийн шаардлага, үндсэн агуулга, хэрэгжүүлэх

	бэлтгэх шатанд ижил агуулга тодорхойлогддог.	үндэслэлийн хэсгээр тодорхойлдог.	хуваарь, болзошгүй асуудал, бодлогын үндэслэлийг тодорхойлдог
--	--	-----------------------------------	---

Австрали, ХБНГУ, БНСУ-д Монгол Улсад хэрэглэдэгтэй ижил “хуулийн төслийн үзэл баримтлал” гэсэн нэртэй тусдаа баримт бичиг боловсруулахыг шаарддаггүй боловч түүнтэй дүйцэх процесс хийгддэг байна. Австралид үзэл баримтлалын төсөлтэй дүйцэх агуулгыг бодлогыг эцэслэх, бодлогын зөвшөөрөл авах, ОРС-д зориулсан хуулийн төсөл боловсруулах заавар бэлтгэх шатанд тодорхойлогддог. Энэхүү зааварт бодлогын зорилт, зохицуулалтын харилцаа, хамрах хүрээ, хэрэгжүүлэх механизм, эрх, үүрэг, хяналт, хариуцлагыг нарийвчлан тусгасан болно. ХБНГУ-д тусад нь үзэл баримтлалын баримт бичиг байдаггүй ч хуулийн төслийн бүтэц, үндэслэл, үр дагаварт тулгамдаж буй асуудал, зорилт, шийдвэрлэх арга зам, хувилбарууд, төсөвт үзүүлэх нөлөөлөл, хэрэгжүүлэх зардал зэргийг тусгасан байдаг. БНСУ-д хууль тогтоомжийн төлөвлөгөө, хуулийн төсөл нь хууль эрх зүйн шаардлага, үндсэн агуулга, хэрэгжүүлэх хуваарь, гарч болзошгүй хүндрэл, бодлогын үндэслэлийг тодорхойлсон байдаг.

6. Хуулийн төсөлд үр нөлөө, зардлын тооцоо хийдэг эсэх

Хүснэгт 3.7. Үр нөлөөний үнэлгээ ба зардлын тооцоолол

	Австрали улс	Герман улс	Бүгд Найрамдах Солонгос Улс
Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцоолол хийж буй байдал	Impact Analysis болон Cost-Benefit Analysis ашигладаг. Мөнгөөр илэрхийлэхэд хүндрэлтэй нөлөөг чанарын болон тоон байдлаар заавал тусгахыг шаарддаг.	Хуулийн төслийн бүтэц, үндэслэл, үр дагаврыг боловсруулах үе шатанд төсөвт үзүүлэх нөлөө, хэрэгжилтийн зардал, иргэн, аж ахуй нэгж, захиргаанд үзүүлэх ачаалал зэргийг тооцдог.	Хэрэв хуулийн төсөл нь төсөвт их хэмжээний ачаалал бий болгохоор байвал 5 жилийн хугацаатай хийнэ.

Харьцуулалтаас үзэхэд Австрали, ХБНГУ, БНСУ-д хуулийн төсөл боловсруулах үед үр нөлөө, зардлыг урьдчилан тооцох тогтолцоо байдаг боловч хамрах хүрээ, аргачлалын хувьд ялгаатай байна. Австрали Улс Impact Analysis болон Cost-Benefit Analysis ашиглан тухайн зохицуулалтын нийгэм, эдийн засагт үзүүлэх зардал, үр ашиг, эрсдэл, хуваарилалтын нөлөөг үнэлдэг. Зохицуулалтын хувилбаруудыг тодорхойлон хувилбар бүрээс үүсэх зардлын шинж чанар нөлөөллийг тодорхойлж зардлыг тооцдог. Жишээ нь: Тухайн зардал нь нэг удаагийн зардал, жил бүр давтагдах, тогтмол эсвэл хувьсах зардал гэх мэт хувилбараас шалтгаалан шаардлагатай бүх зардлыг тооцоолдог.

ХБНГУ-д хуулийн төслийн үндэслэл, үр дагаврын хүрээнд төсөвт үзүүлэх нөлөө, хэрэгжилтийн зардал, иргэн, аж ахуйн нэгж, захиргаанд үүсэх цаг хугацааны болон мөнгөн зардлыг тусад нь тооцно. Зардлын тооцооллыг тухайн хуулийн төслийг боловсруулж буй холбооны яам хийж, шаардлагатай тохиолдолд Холбооны статистикийн газар арга зүйн дэмжлэг үзүүлдэг. Үндэсний хэм хэмжээний хяналтын зөвлөл (NKR) нь тооцооллын үндэслэл, ойлгомжтой байдал, аргачлалын нийцлийг хянадаг байна.

БНСУ-д хуулийн төсөл хэрэгжсэнээр улсын болон орон нутгийн төсөвт үүсэх зарлага, орлогын өөрчлөлт, санхүүжилтийн эх үүсвэрийг урьдчилан тооцож, парламентын хэлэлцүүлэгт санхүүгийн үндэслэл болгон ашигладаг. Үндэсний Ассамблейн гишүүн төсөв, санхүүгийн арга хэмжээ дагалдах хуулийн төсөл санаачлах бол National Assembly Budget Office (NABO) буюу Үндэсний Ассамблейн Төсвийн албанаас боловсруулсан зардлын тооцоо, эсхүл зардлын тооцоо хийлгэх хүсэлтийг хамт ирүүлнэ. Засгийн газар төсөв, санхүүгийн арга хэмжээ дагалдах хуулийн төсөл өргөн мэдүүлэх бол зардлын тооцоо болон түүнд харгалзах санхүүжилтийн эх үүсвэрийн төлөвлөгөө-г хавсаргана гэж заасан байна.

7. Хууль тогтоомжийн төсөлд хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ хийж байгаа эсэх

Хүснэгт 3.8. Хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ хийж байгаа эсэх

	Австрали улс	Герман улс	Бүгд Найрамдах Солонгос Улс
Хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ	Хүний эрхийн үүднээс хуулийн төсөл бүрийн үнэлгээг заавал хийх шинжтэй. Хуулийн	Тусдаа “хүний эрхийн нөлөөллийн үнэлгээ” гэсэн нэг баримт бичиг бүх төсөлд заавал	Хуулийн төсөл хүний эрхэд нөлөөлөх эсэхийг шалгана. Хууль тогтоомжийн

	төсөл хүний эрхэд яаж нөлөөлөхийг Үндсэн хууль, олон улсын гэрээ, хүний эрхийн дүгнэлт болон талуудын зөвшилцөлд тулгуурлаж үнэлдэг.	байхгүй. Гэхдээ Үндсэн хууль, үндсэн эрх, олон улсын гэрээ, хүүхэд, хөгжлийн бэрхшээл, жендер, хувийн мэдээлэл зэрэг эрхийн асуудлыг хуулийн төслийн үндэслэл, эрх зүйн хяналт, яам хоорондын оролцоогоор шалгадаг.	төсөлтэй хамт хүний эрхийн нөлөөллийн баримт хавсаргах ёстой.
--	--	---	---

Хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээний хувьд гурван улсын арга барил харилцан ялгаатай байна. Австрали Улс хүний эрхийн үнэлгээг хамгийн тодорхой хэлбэрээр хэрэгжүүлдэг бөгөөд хуулийн төсөл хүний эрхэд хэрхэн нөлөөлөхийг Үндсэн хууль, олон улсын гэрээ, хүний эрхийн зарчим, холбогдох талуудын зөвшилцөлд тулгуурлан үнэлдэг. Энэ нь хүний эрхийн асуудлыг хууль тогтоомж боловсруулах ажиллагааны зайлшгүй бүрэлдэхүүн хэсэг болгож байгаагаараа онцлогтой.

ХБНГУ-д бүх хуулийн төсөлд тусдаа “хүний эрхийн нөлөөллийн үнэлгээ” гэсэн нэг баримт бичиг заавал хавсаргах тогтолцоо байхгүй боловч хүний эрхийн асуудлыг Үндсэн хууль, үндсэн эрх, олон улсын гэрээ, хувийн мэдээлэл, жендер, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх зэрэг чиглэлээр хуулийн төслийн үндэслэл, эрх зүйн хяналт, холбогдох яамдын оролцоогоор шалгадаг. БНСУ-д хүний эрхийн асуудлыг жендер, хувийн мэдээлэл, авлигын эрсдэл, орон нутгийн өөрөө удирдах зарчим зэрэг салбарчилсан урьдчилсан нөлөөллийн үнэлгээний хүрээнд авч үздэг гэж дүгнэж болно. Эндээс үзэхэд хүний эрхийн үнэлгээ нь улс бүрд нэг ижил хэлбэрээр хэрэгждэггүй боловч нийтлэг зорилго нь хуулийн төсөл хүний эрх, эрх чөлөөг үндэслэлгүйгээр хязгаарлах, ялгаварлан гадуурхах, хувийн мэдээлэл болон эмзэг бүлгийн эрхэд сөргөөр нөлөөлөхөөс урьдчилан сэргийлэхэд оршиж байна.

8. Хууль тогтоомжийн төсөл нь олон нийтийн оролцоог хангасан эсэх

Хүснэгт 3.9. Олон нийтийн оролцоог хэлэлцүүлэг хийж, санал авдаг эсэх

	Австрали улс	Герман улс	Бүгд Найрамдах Солонгос Улс
Олон нийтийн оролцоог хангасан байдал	Хэрэгжилтийн нарийвчилсан асуудлаар салбарын төлөөллийн байгууллага болон зохицуулагчтай зөвлөлдөх, мөн нөлөөлөл, эсхүл ойлгомжтой байдлын талаар олон нийтийн зөвлөлдөөн хийх болно.	Холбооны муж, орон нутгийн дээд холбоод, мэргэжлийн хүрээлэл, холбоодыг оролцуулах ажиллагаа GGO-ийн дагуу хийгддэг.	Олон нийтийн оролцоо нь RIA-гийн чухал хэсэг гэж үздэг учир заавал хийдэг.

Олон нийтийн оролцооны хувьд Австрали, ХБНГУ, БНСУ нь хууль тогтоомж боловсруулах ажиллагаанд иргэд, мэргэжлийн байгууллага, салбарын төлөөлөл, холбоод, зохицуулагч байгууллагын саналыг тусгах тодорхой хэлбэрүүдтэй байна. Австралид хуулийн төсөл боловсруулах явцад хэрэгжилтийн нарийвчилсан асуудлаар салбарын төлөөллийн байгууллага, зохицуулагчтай зөвлөлдөхөөс гадна хуулийн төслийн нөлөөлөл, ойлгомжтой байдал, хэрэгжих боломжийн талаар олон нийтийн зөвлөлдөөн хийж болно. ХБНГУ-д холбооны муж, орон нутгийн дээд холбоод, мэргэжлийн хүрээлэл, холбоодыг оролцуулах ажиллагаа GGO-ийн дагуу хийгддэг нь холбооны улсын бүтэцтэй уялдсан институтчилсэн оролцооны хэлбэр юм. БНСУ-д олон нийтийн оролцоо нь зохицуулалтын нөлөөллийн үнэлгээ болон урьдчилан нийтэд мэдээлэх ажиллагааны чухал хэсэг бөгөөд хуулийн төслийг олон нийтэд мэдээлж, санал авах хугацаа, хэлбэрийг тогтоодог.

ДҮГНЭЛТ

Энэхүү дипломын төслийн судалгааны хүрээнд Монгол Улсын “Хууль тогтоомжийн тухай хууль”-ийн хэрэгжилт, хуулийн төслийн зардлын тооцоолол болон үр нөлөөний үнэлгээний өнөөгийн байдлыг Австрали, БНСУ, ХБНГУ-ын тогтолцоотой харьцуулан судалсны үндсэн дээр дараах дүгнэлтэд хүрлээ.

Нэгдүгээрт, Монгол Улсад Хууль тогтоомжийн тухай хууль батлагдсанаар хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажиллагаанд тандан судалгаа хийх, үзэл баримтлал боловсруулах, зардлын тооцоо гаргах, үр нөлөөг үнэлэх, олон нийтийн оролцоог хангах зэрэг шаардлагын эрх зүйн үндэс бүрдсэн байна. Тухайлбал, Хууль тогтоомжийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалд тухайн төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлага, зорилго, зохицуулах харилцаа, хамрах хүрээ, батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, бусад хуультай уялдах байдлыг тусгах шаардлагыг тогтоосон. Энэ нь хууль тогтоомжийг шинжлэх ухааны үндэслэлтэй, урьдчилсан судалгаанд тулгуурлан боловсруулах эрх зүйн чухал баталгаа юм.

Хоёрдугаарт, Хууль тогтоомжийн тухай хуульд заасан дээрх шаардлагууд бодит практикт бүрэн, жигд, чанартай хэрэгжиж чадахгүй байна. Судалгаанд хамруулсан 30 хуулийн төслөөс 20 төсөлд хэрэгцээ шаардлагын тандан судалгаа эсхүл хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, 23 төсөлд үр нөлөөний үнэлгээ, 21 төсөлд зардлын тооцоолол хийгдсэн байна. Энэ нь хуулийн төслийн бүрдүүлбэрийн шаардлага тодорхой хэмжээнд хангагдаж байгаа боловч бүх төсөлд адил түвшинд хэрэгжихгүй, зарим тохиолдолд судалгаа, үнэлгээ, тооцоолол дутуу буюу формаль шинжтэй байгааг харуулж байна.

Гуравдугаарт, хуулийн төслийн зардлын тооцоолол нь зөвхөн улсын төсөвт үүсэх санхүүгийн зардлаар хязгаарлагдах ёсгүй. Хууль тогтоомжийн тухай хууль болон Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан аргачлалын агуулгаас үзэхэд хууль хэрэгжихэд иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад үүсэх зардал, цаг хугацаа, хүний нөөц, зохион байгуулалтын ачаалал, мэдээлэл боловсруулах болон тайлагнах үүрэг зэрэг өргөн хүрээний зардлыг тооцох шаардлагатай. Гэвч практикт зарим хуулийн төсөлд зардлын тооцооллыг ерөнхий байдлаар, тоон үндэслэл багатай, хэрэгжилтийн бодит нөхцөлтэй хангалттай уялдуулаагүй хийж байна.

Дөрөвдүгээрт, хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ нь тухайн зохицуулалт зорилгодоо хүрэх эсэх, иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллага, нийгэм, эдийн засаг, хүний эрхэд ямар нөлөө үзүүлэхийг урьдчилан тогтоох үндсэн арга хэрэгсэл юм. Гэвч

судалгааны үр дүнгээс харахад үр нөлөөний үнэлгээ нь зарим тохиолдолд тухайн хуулийн бодит хэрэгжилт, эрсдэл, сөрөг үр дагаврыг тодорхойлох бус, төслийн бүрдүүлбэрийг хангах зорилгоор хийгдсэн мэт ерөнхий шинжтэй байна. Энэ нь хууль батлагдсаны дараа хэрэгжилтийн хүндрэл, давхардал, хийдэл, төсөв санхүүгийн нэмэлт дарамт, эрх зүйн тодорхойгүй байдал үүсэх эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Тавдугаарт, Монгол Улсад хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал, хууль зүйн үндэс тодорхой хэмжээнд бүрдсэн боловч тэдгээрийн хэрэгжилтэд тавих хяналт, чанарын шалгалт, хариуцлагын тогтолцоо хангалтгүй байна. Иймээс хуулийн төслийн зардлын тооцоо, үр нөлөөний үнэлгээ хангалтгүй хийгдэж байгаа гол шалтгаан нь зөвхөн аргачлалын дутагдал бус, харин уг аргачлалыг хэрэгжүүлэх байгууллагын чадавх, хяналтын механизм, хариуцлагын зохицуулалт сул байгаатай холбоотой гэж дүгнэж байна.

Зургаадугаарт, Австрали, БНСУ, ХБНГУ-ын туршлагаас үзэхэд хуулийн төслийн чанарыг сайжруулахад зохицуулалтын үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцоолол, олон нийтийн оролцоо, хараат бус буюу мэргэжлийн хяналтын тогтолцоо чухал үүрэгтэй байна. Эдгээр улсын туршлага нь Монгол Улсад Хууль тогтоомжийн тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулахад зөвхөн хуульд шаардлага тусгах бус, тухайн шаардлагын биелэлтийг шалгах, үнэлэх, буцаах, сайжруулах институцийн механизмыг бүрдүүлэх шаардлагатайг харуулж байна.

ЗӨВЛӨМЖ

Монгол Улсад “Хууль тогтоомжийн тухай хууль”-ийн хэрэгжилтийг сайжруулах, хуулийн төслийн чанарыг дээшлүүлэх зорилгоор дараах санал зөвлөмжийг дэвшүүлж байна.

1. **Хуулийн төсөл боловсруулах үе шат бүхэнд холбогдох хяналтийн байгууллагыг тогтоож өгөх.** Ингэснээр хуулийн төслийг системтэй зохион байгуулах хууль тогтоомжийн чанарыг хангах үндэс болно.
2. **Хуулийн төслийн бүрдүүлбэрийг шаардлагыг чангатгах.** Хуулийн төслийн өргөн мэдүүлэхээс өмнө хяналтын байгууллагаар бүрдүүлбэрийн бүрэн бүтэн байдлыг хангасан эсэхийг шалгуулах.
3. **Үр нөлөөний үнэлгээг бодит судалгаанд тулгуурлуулах** Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэхдээ зөвхөн тайлбар бичиг, хууль санаачлагчийн үндэслэлд тулгуурлах бус, статистик мэдээлэл, харьцуулсан судалгаа, салбарын мэргэжилтнүүдийн дүгнэлт, иргэдийн санал асуулга, туршилтын үнэлгээг ашиглах нь зүйтэй.
4. **Олон нийтийн оролцоог хэлбэр төдий бус, бодитой болгох** Хуулийн төсөлд санал авах ажиллагааг олон нийтэд хүртээмжтэй байдлаар зохион байгуулж, ирүүлсэн саналын тоо, агуулга, тусгасан болон тусгаагүй үндэслэлийг нээлттэй тайлагнадаг байх хэрэгтэй. Энэ нь хууль тогтоомжийн ил тод байдал, хүлээн зөвшөөрөгдөх байдлыг нэмэгдүүлнэ.
5. **Хууль санаачлагчийн хариуцлагыг нэмэгдүүлэх** Хуулийн төслийг өргөн мэдүүлэхдээ зардлын тооцоолол, үр нөлөөний үнэлгээ, олон нийтийн санал авсан байдал хангалтгүй бол төслийг буцаах, дахин боловсруулах шаардлага тавих эрх зүйн болон процедурын зохицуулалтыг тодорхой болгох нь зүйтэй.
6. Австрали, БНСУ, ХБНГУ-ын туршлагаас Монгол Улсад нэвтрүүлэх боломжтой гол механизм нь хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцооллыг мэргэжлийн түвшинд хянадаг тогтолцоо юм. Ийм хяналтын механизм бий болсноор хуулийн төсөл боловсруулах ажиллагаа илүү нотолгоонд суурилсан, ил тод, хариуцлагатай болох боломжтой.

НОМ ЗҮЙ

1. Эрх зүйн эх сурвалж:

1. Хууль тогтоомжийн тухай хууль, 2015 он.
2. Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралт,
3. Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралт,

2. Монгол хэл дээрх эх сурвалж:

1. Рэнцэнгийн Уранбилэг, Эрх зүйн социологи, (2002 он), 128-131 дэх тал
2. М.Маралмаа, Б.Р., “Хууль, тогтоомжийн төсөл судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх зарчмын хэрэгжилт”, forum.mn, 2025 он.
3. С.Оюунтуяа, “Хууль тогтоомжийн тухай хуулийн хэрэгжилт: Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн жишээн дээр авч үзэх нь”, forum.mn, 2022 он.
4. Т.Мөнх-Эрдэнэ, Ц.Одонжав, Ц.Мөнх-Эрдэнэ, Э.Эрхбилгүүн, “Хууль тогтоомжийн хуультай холбоотойгоор бусад улс орнуудын нийтлэг чиг хандлага, сайн туршлагын талаар харьцуулсан судалгаа”, forum.mn, 2021 он.
5. Ц.Норовдондог, Ш.Рэнчин-Очир, “Хууль, тогтоомжийн төслийн зардал, үр нөлөөг шинжлэх арга зүй: Олон улсын туршлага”, Парламент судалгааны эмхэтгэл, forum.mn, 2022 он.

3. Гадаад хэл дээрх эх сурвалж:

А. Англи хэл дээрх эх сурвалж:

- А. Australian Government Department of the Prime Minister and Cabinet, “Guide to the legislation process”, n.d.
- Б. Office of Parliamentary Counsel, “Drafting Direction No. 4.6 Legislation Approval Process”, 2025 он.

Б. Герман хэл дээрх эх сурвалж:

- В. Bundesministerium des Innern und für Heimat, Gemeinsame Geschäftsordnung der Bundesministerien, n.d.

В. Солонгос хэл дээрх эх сурвалж:

- Г. Korea Legislation Research Institute, “Statutes of the Republic of Korea: Legislation Procedures”, n.d.

4. Цахим эх сурвалж:

1. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: <https://legalinfo.mn/mn>.
2. Монгол Улсын Их Хурлын хуулийн төсөл хэлэлцүүлгийн цахим систем: <https://lawforum.parliament.mn/project/492/>.
3. Улсын Их Хурлын Тамгын газрын цахим хуудас: <https://www.parliament.mn/>.
4. NYU Law Global цахим хуудас: <https://www.nyulawglobal.org/>.
5. Австралийн Засгийн газрын Ерөнхий сайд ба Засгийн газрын хэрэг эрхлэх газар цахим хуудас: <https://www.pmc.gov.au/>.
6. БНСУ-ын Засгийн газрын хууль тогтоомжийн яам цахим хуудас: <https://moleg.go.kr/english/>.
7. Захиргааны зохицуулалтын баримт бичгүүдийн цахим хуудас: <https://www.verwaltungsvorschriften-im-internet.de/>.